# HED

Higher Education Discovery

Олон улсын сэтгүүл




ОРОС МОНГОЛ:
100 ГАРУЙ ЖИЛИЙН
НӨХӨРЛӨЛ

МОНГОЛ УЛСАД ЗОРИУЛСАН
600 БОЛОВСРОЛЫН КВОТ

ЗХУ БОЛОН ОРОСЫН
ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН
60 000+ ТӨГСӨГЧИД
МОНГОЛД
АМЬДАРДАГ

# МОНГОЛ ЭЛСЭГЧДЭД ЗОРИУЛСАН ОРОСЫН БОЛОВСРОЛ

**ЭҮСТИС-ийн оюутан болоорой!**

ИРКУТСКИЙ НАЦИОНАЛЬНЫЙ ИССЛЕДОВАТЕЛЬСКИЙ ТЕХНИЧЕСКИЙ УНИВЕРСИТЕТ

**Эрхүүгийн үндэсний судалгааны техникийн их сургууль**

Оросын боловсролын тухай анхны олон хэлтэй сэтгүүл

**hedclub.com**



«Россотрудничество»-ийн дэмжлэгтэйгээр

1 хавтас дээрх зургийг Эрхүүгийн Үндэсний судалгааны техникийн их сургуулиас сурталчилгааны эрхтэйгээр гаргаж өгсөн.

Өгсөн зургийн зохиогчийн эрхийг хангах ба илгээсэн материалын агуулгыг хариуцлагыг сурталчлагч хүлээнэ.

# Агуулга


| | |
|---|---|
| **Монголоос элсэх элсэгчдэд зориулсан Оросын дээд боловсрол** | 6 |
| **Монгол Улсаас элсэгч хүлээн авах онцлогууд** | 12 |
| **Төслийн оролцогч их сургуулиудын HED газрын зураг** | 20 |
| **Оростой танилц. Белгород** | 22 |
| **Белгородын улсын үндэсний судалгааны их сургууль** | 24 |
| **Москвагийн улсын технологийн их сургууль «СТАНКИН»** | 30 |
| **А. Н. Косыгины нэрэмжит Оросын улсын их сургууль (Технологи. Загвар. Урлаг)** | 34 |
| **И. М. Губкины нэрэмжит Оросын газрын тос, байгалийн хийн улсын их сургууль (үндэсний судалгааны их сургууль)** | 38 |
| **Н. И. Пироговын нэрэмжит Оросын үндэсний судалгааны анагаах ухааны их сургууль** | 42 |
| **Эзэн хаан I-р Александрын Санкт-Петербургийн зам харилцааны улсын их сургууль** | 48 |
| **Санкт-Петербургийн архитектур барилгын улсын их сургууль** | 52 |
| **Санкт-Петербург хотын улсын агаарын сансрын багаж хэрэгслийн их сургууль** | 56 |
| **Санкт Петербургийн үйлдвэрлэлийн технологи, дизайны улсын их сургууль** | 60 |
| **Номхон далайн улсын их сургууль** | 66 |
| **Оросын их дээд сургуулиудын квотын шалгаруулалт** | 70 |

# Энэ дугаарт

## 6

«Россотрудничество»-ийн төлөөлөгчийн газар нь Оросын Засгийн газрын квотоор гадаадын иргэдийг элсүүлэх авах Монгол дахь цорын ганц оператор юм.





## 8

Русский Дом нь монголчуудын суралцдаг орос сургуулиудтай идэвхтэй хамтран ажилладаг.

## 12

Оросын их дээд сургуульд элсэхэд анхаарах зүйлс.



## Бид WeChat-д

WeChat

ID: HEDmagazine



**13**

Монголчууд яагаад оросын боловсролыг сонгодог вэ.

**70**

Оросын их сургуулиас урилга авах нэг арга бол гадаадаас элсэгчдийн дунд явагдах сонгон шалгаруулалтад амжилттай оролцох юм.





**72**

Ирүүлсэн нэр дэвшигч бүрийг хэлэлцсэний үр дүнгийн тухай мэдээллийг Оросын Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Россотрудничество руу илгээдэг.

Найзууд аа!

Манай хамт олон энэ сэтгүүлийг сонирхолтой бөгөөд ашиг тустай байлгахын тулд маш их хичээж ажилласан. Бид хамтдаа сэтгүүлийг илүү сайн болгож чадна! Хэрэв та туршлагаа хуваалцах, ирээдүйн төлөвлөгөөний тухай ярих эсвэл сэтгэгдэл үлдээх хүсэлтэй байгаа бол цахим шуудангаар холбогдоорой **kleshnina.es@hedclub.com**.



24
«БелГУ» УСИС




30
«СТАНКИН» МУТИС




34
Косыгины их сургууль




38
Губкины их сургууль



42
Н. И. Пироговын нэрэмжит ОУСАУИС



48
СПЗХУИС






52 СПАБУИС





56 ГУАП





60 СПУТДУИС





66 НДУИС




*2022 онд Улаанбаатар хот дахь Орос хэлний сургалт төгссөн тухай гэрчилгээг Монгол Улсын 158 иргэн авсан*

# Монголоос элсэх элсэгчдэд зориулсан Оросын дээд боловсрол

**Монгол Улсад Оросын боловсролын түвшинг өндрөөр үнэлж, манай улсын соёлыг ихэд сонирхож байна. Оросын их дээд сургуульд суралцах квотын тоо нэмэгдэж байна. «Россотрудничество»-ийн зохион байгуулдаг биечлэн оролцоотой болон зайны арга хэмжээнүүдийн ачаар их сургуулийн төлөөлөгчид дунд сургуулийн сурагчидтай танилцаж, хамгийн авъяаслаг хүүхдүүдийг сонгох боломжтой байдаг.**

**Монголоос элсэж буй элсэгчид Оросын их дээд сургуульд хэрхэн элсдэг, ямар мэргэжлээр суралцдаг гэх мэт олон сонирхолтой зүйлийн тухай «Россотрудничество»-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч, Улаанбаатар хот дахь «Русский дом»-ын захирлын үүрэг гүйцэтгэгч Валерия Килпякова ярьж байна.**



## ОРОСЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬД ЭЛСЭХ ШАЛТГААНЫ ТУХАЙ

Оросын дээд боловсролын нэр хүнд социализмын дараах үеийн эхэнд бага зэрэг буурсан боловч одоо ч гэсэн хангалттай өндөр түвшинд хадгалагдаж үлдсэн хэвээр байна.

Нэгдүгээрт, социализмын үед Монголд бүтээн байгуулагдсан бөгөөд технологийн хувьд Зөвлөлт/Оросын стандартад суурилсан Улаанбаатар төмөр зам, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, ДЦС-ийн зэрэг дэд бүтэц одоо ч гэсэн үйл ажиллагаагаа явуулж байна. **Технологийн хувьд нарийн бүтэцтэй объектуудын засвар үйлчилгээ болон мэдээллийн тогтмол шинэчлэлтийг хангахад зөвхөн Оросод бэлтгэгдсэн зохих мэргэжилтнүүд шаардлагатай байдаг.**

Хоёрдугаарт, социализмын үед, тэр дундаа хамтарсан судалгааны экспедицийн системээр хөгжсөн шинжлэх ухаан, боловсролын хэлхээ холбоо алга болоогүй байна. **Шинжлэх ухааны судалгааг үргэлжлүүлэх шаардлага нь монгол залуусыг Оросын их дээд сургуульд сургах замаар шинэ боловсон хүчин бэлдэх нөхцөлийг бодитоор бүрдүүлсэн.** Монголын ахмад үеийнхэн залуучуудын сэтгэлгээнд нөлөөлж буй хүчин зүйл бас маш их ач холбогдолтой.

**8 000**
Оросын их дээд сургуулиудад 8000 монгол оюутан суралцаж байна

**≈70 000**
Монгол Улсын 70 мянга орчим иргэн ЗХУ ба Оросод дээд боловсрол эзэмшсэн

## КВОТЫН ТУХАЙ

Квотын тоо жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд өрсөлдөөн бага хэвээр байна. Цар тахлын улмаас Оросын их дээд сургуулиудын өрсөлдөөн нэг байранд 2 хүн болж буурсан. Сургуулийн сургалтын хөтөлбөрт орос хэлний хичээл хангалтгүй байгаагаас орос хэлний мэдлэг муу байгаа нь их чухал ач холбогдолтой байна: 7-8 ангид долоо хоногт 2 цаг, 9-р ангид 3 цаг, төгсөлтийн 12-р ангид орос хэл огт заахгүй байгаа.



**Монгол Улсын иргэдэд зориулсан боловсролын квотууд**



## ОРОСЫН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС ХАЙХ ТУХАЙ

Ихэнхдээ Оросын их дээд сургуулиудын тухай мэдээллийг олон нийтийн сошиал сүлжээгээр (Улаанбаатар дахь Русский дом Facebook хуудас (Meta нь ОХУ-ын нутаг дэвсгэрт хориотой) 25 000 дагагчтай), хамаатан садан, найз нөхөд, Монгол Улсын Боловсролын яамны цахим хуудас, радио, ТВ-ээс хайж байна.

Русский дом нь Facebook дээр шууд нэвтрүүлэг хийж (Meta нь ОХУ-ын нутаг дэвсгэрт хориотой), их дээд сургуулиудын оролцоотойгоор боловсролын онлайн үзэсгэлэн ба ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээ зохион байгуулдаг. Ийм зайнаас хийх уулзалтуудыг 2021 оны сүүлийн хагасаас идэвхтэй зохион байгуулж эхэлсэн.

Оросод суралцах боломжуудын тухай мэдээллийг Русский Домын дэргэдэх Орос хэлний төвүүдээр (ОХТ) дамжуулдаг. Монгол даяар 53 ОХТ ажилладаг: 24 нь Улаанбаатарт, 29 нь аймаг орон нутагт.

Аймаг орон нутагт орос хэлний олимпиад зохион байгуулснаар алс холын аймгуудын авьяаслаг хүүхдүүд Оросын Засгийн газрын төсвийн зардлаар Оросын их дээд сургуульд үнэ төлбөргүй суралцах эрхийн гэрчилгээ авах боломжтой болдог.

Русский дом монголчуудын суралцдаг орос сургуулиудтай идэвхтэй хамтран ажилладаг. Жишээлбэл, Г. В. Плехановын нэрэмжит ОЭЗИС-ийн салбартай – 1 700 сурагч, Монгол-Оросын хамтарсан 3-р сургуультай – 2 700 сурагч.







## ЭЛСЭЛТИЙН ТУХАЙ

«Россотрудничество»-ийн төлөөлөгчийн газар нь Оросын Засгийн газрын квотоор гадаадын иргэдийг элсүүлж авах Монгол дахь цорын ганц оператор юм. Залуучууд education-in-russia.com сайтад бүртгүүлж, хувийн амжилтын шалгаруулалтад оролцдог.


*Валерия Кильпякова*

Хувийн амжилтын шалгаруулалтыг «Россотрудничество»-ийн төлөөлөгчийн газар 2020 оноос хойш зохион байгуулж байна. Ковидын өмнөх цаг үед их дээд сургуулиудын төлөөлөгчид сонгон шалгаруулалтыг тест хэлбэрээр явуулдаг байсан.

> **Их сургуулийн нэгдүгээр курст орохоор төлөвлөж буй залуучууд ярилцлагад орно. Үндсэндээ тэдний ихэнх нь Оросын боловсролын хөтөлбөрийн дагуу сургалт явуулдаг сургуулийн төгсөгчид байдаг. Үлдсэн монгол элсэгчид бэлтгэл ангид суралцдаг тул тэдний дунд хувийн амжилтын шалгаруулалт зохион байгуулдаг.**

Шалгаруулалтад тэнцэж, элсэгчдийн жагсаалтад орохын тулд залуучууд үндсэн хичээлийн олимпиад, түүнчлэн орос хэл болон бусад хичээлийн тэмцээн уралдаанд идэвхтэй оролцох ёстой. Их сургуулийн олимпиад нь элсэгчийн хувийн амжилтын оноог нэмнэ, мөн түүний нийгмийн болон сайн дурын ажлын идэвх, биеийн тамир, соёл, боловсролын уралдаан, наадам, эрдэм шинжилгээний хуралд оролцсон байдлыг харгалзан үздэг.

Гэхдээ Оросод суралцахыг мөрөөддөг залууст өгөх гол зөвлөгөө бол Facebook дахь Русский Дом хуудсыг дагаж (Meta нь ОХУ-ын нутаг дэвсгэрт хориотой), сонгон шалгаруулалт эхлэх тухай ба баримт бичигт тавигдах шаардлагын тухай зарлал болон мэдээллийн материалыг анхааралтай уншиж байх хэрэгтэй.

**Энэ мөчөөс эхлэн элсэгч бүрийн хувийн хариуцлага эхэлдэг бөгөөд энэ нь сонгон шалгаруулалтад тэнцэх эхний алхам юм.**



ЭУСТИС-ийн монгол оюутнууд

## ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛҮҮДИЙН ТУХАЙ

Оросын дээд боловсролын тогтолцоо нь эдийн засгийн олон салбарын мэргэжилтэн бэлтгэх өндөр чанарын суурьтай байдаг тул дунд сургуулийн сурагчид, оюутнууд, тэр дундаа монгол оюутнуудтай хийх мэргэжлийн чиг баримжаа олгох идэвхтэй ажил үргэлж ач холбогдолтой байдаг. Бидний одоогийн гол зорилт бол залуучуудын анхаарлыг зөвхөн нийслэлийн эсвэл Санкт-Петербург хотын бус, харин Оросын бүс нутгийн их дээд сургуулиудад хандуулах явдал юм. Красноярск, Новосибирск, Улаан-Үд болон Монголтой ойр байгаа бусад бүс нутагт маш сайн сургуулиуд байдаг.

Монгол оюутнуудын дунд эрэлт ихтэй чиглэлүүд гэвэл анагаах ухаан, хууль зүй, олон улсын харилцаа, эдийн засаг зэрэг салбарууд байна. «Сэтгэл судлал»-ын чиглэлээр суралцах хүсэлтэй элсэгчдийн тоо нэмэгдэж байна. Мэдээллийн технологи болон инженерийн чиглэлүүд эрэлттэй болж байна.



ЭУСТИС-ийн монгол оюутнууд

**Ойрын жилүүдэд Монголд «Союз Восток» хийн хоолой баригдахтай холбогдуулан «Цахилгаан эрчим хүч, цахилгааны техник», «Газрын тос, байгалийн хийн мэргэжил», «Газрын тосны үйлдвэрлэлийн технологийн процессын автоматжуулалт» зэрэг чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай болж магадгүй байна.** Томск хотын Политехникийн их сургууль ирэх хичээлийн жилээс Монголоос оюутан элсүүлэн авч, сургаж эхлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн байгаа.

Одоогоор Монгол Улсын 300 гаруй иргэн ТПУ-ын дипломтой. Одоо бий болж буй Улаанбаатар дахь Русский Дом – «Союз Восток» хийн хоолой – ТПУ хэмээх холбоо нь ирээдүйн үр ашгийн төлөө ажиллаж байна. **Монголоор дайран өнгөрөх хийн хоолойн хэсэгт зориулсан боловсон хүчин тун удахгүй хэрэг болж магадгүй бөгөөд монгол залуус нэр хүндтэй, эрэлттэй мэргэжилтэй болох бүрэн боломжтой байна.**




# Монгол Улсаас элсэгч хүлээн авах онцлогууд



2022 онд Зөвлөлт, Оросын их дээд сургуульд монгол оюутнууд суралцаж эхэлсний 100 жилийн тохиож буй бөгөөд манай найрсаг хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоогдоод зуу гаруй жил болж байна. Монгол оюутнуудын хувьд Оросд суралцах нь сайн боловсрол эзэмшихээс гадна баялаг соёл, гайхалтай урлагтай гайхамшигт улсад амьдрах боломж юм. Дунд сургууль төгсөгчид Оросын их дээд сургуулиудад дээд, дунд болон нэмэлт мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой байдаг.

Монгол оюутнуудыг Оросын дээд боловсролтой илүү сайн танилцуулахын тулд Оросын их дээд сургуульд элсэхэд ач холбогдол бүхий мэдээллийг бид танилцуулж байна.

**Доржнямын Бямбасурэн, Буриадын улсын хөдөө аж ахуйн академийн магистр, агрономич**

Миний хувьд мэргэжлийн замналын өсөлт маш чухал. Юуны өмнө би өөрөөсөө «Хэрвээ би энэ улсыг, энэ улсын их сургуулийг сонгох юм бол Монголд бодит амьдрал дээр надад ямар давуу талтай болох вэ» гэж асуудаг. Тиймээс би өөрийн сонирхол болон ирээдүйн төлөвлөгөөнд тулгуурлан орос их сургуулийг сонгосон.

Буриад Улс, тэр дундаа Селенгинский районы мал аж ахуйн арга барил нь Монголын төвийн аймгуудтай тун төстэй байдаг учир би энэ сонголтыг хийсэн. Оросын их сургуулийг төгссөний дараа би олж авсан мэдлэгээ эх орондоо хэрэгжүүлч чадна.

**Мунгуншагай Давыд, Буриадын улсын их сургуулийн аспирант, улс төр судлаач**

Би их сургуулиа Монгол Улстай ойрхон учраас сонгосон. Тиймээс би аль хот, ямар их сургуулиуд ойрхон байгааг судалж эхэлсэн. Мэдээжийн хэрэг, монголчуудын сайн мэдэх Эрхүү хотыг би хамгийн түрүүнд авч үзсэн боловч тэнд элсэх босго нь Улаан-Үдээс өндөр байсан.

**МОНГОЛЧУУД ЯАГААД ОРОСЫН БОЛОВСРОЛЫГ СОНГОДОГ ВЭ?**[1]

1. Мэргэжлийн салбартаа бизнесийн харилцаа тогтоох боломж
2. Оросын соёл ба сэтгэлгээ маш ойрхон
3. Оросын боловсролын нэр хүнд
4. Ижил төстэй уур амьсгал, танил ландшафтаас эхлээд соёл ба хэлний ойр дотно байдал гэх мэт амьдрах тав тухтай нөхцөлүүд




[1] Комбаев А. В., Давыд М. «Зөөлөн хүч» болох Оросын боловсрол: Монгол оюутнуудын боловсролын стратеги // Власть. 2022. 30 том. № 3. Х. 216-220

## ОРОС, МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

1. Уул уурхайн аж үйлдвэр, газрын тос боловсруулалт, хийн эрчим хүч, төмөр замын тээвэр, агаарын тээвэр, логистик
2. Арьс шир, аж үйлдвэр ба нэхмэлийн үйлдвэрлэл, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, агаар ус цэвэршүүлэлт, цэцэрлэгжүүлэлт гадна тохижилт, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулалт ба хадгалалт
3. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сүлжээ супермаркет, аялал жуулчлал (эрүүл мэндийн, экологийн, соёл-түүхийн, экстрим аялал), эрүүл мэнд (эмнэлгийн технологи ба үйлчилгээ, эмийн бэлдмэл ба эмнэлгийн тоног төхөөрөмж), соёл, шинжлэх ухаан, боловсрол

**Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дуламсүрэнгийн Даваа**

Боловсрол, соёлын салбарын хамтын ажиллагаа [ОХУ, Монголын хооронд] чухал байр суурь эзлэж байна. Манай ард түмнүүдийн хоорондын найрамдлын уламжлалыг мэдэх боломжгүй шинэ үеийн залуучууд өссөн. Энэ чиг хандлагыг хамтын хүчин чармайлтаар даван туулах хэрэгтэй байна.

Манай урлагийн салбарын мэргэжилтнүүд буцаад Орост суралцаж эхэлсэн. Манай дуурийн жүжигчид Оросын алдартай театруудад амжилттай ажиллаж байна. Жишээлбэл, Монгол Улсын «Чингис хаан», төрийн дээд одонтой, Монгол Улсын гавьяат жүжигчин, авьяаслаг дуучин Ганбаатарын Ариунбаатар Санкт-Петербург хотын Мариинскийн театрын тайзнаа тоглож байна.

## МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ХЭРЭГЦЭЭ

- Инженер техникийн мэргэжлүүд (жишээлбэл, «Газпром»ын шинэ төсөлд)
- Хөдөө аж ахуйн мэргэжлүүд
- Эмнэлгийн мэргэжлүүд
- Худалдаа, бизнес, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн мэргэжлүүд
- Боловсрол, тээвэр, цэргийн салбарын мэргэжлүүд

## МОНГОЛ ОЮУТНУУДЫН ДУНД ХАМГИЙН ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛҮҮД

- Инженерүүд
- IT-мэргэжилтнүүд
- Эмнэлгийн ажилчид
- Хуульчид
- Эдийн засагчид
- Менежерүүд
- Олон улсын харилцааны мэргэжилтнүүд


unsplash.com


hedclub.com

## ОРОСЫН ИХ ДЭЭД СУРГУУЛИУДЫН ЭЛСЭЛТ

Жил бүр Оросын Засгийн газраас монгол залууст зориулж Оросын их дээд сургуульд суралцах квотууд (оюутнуудад үнэ төлбөргүй) олгодог. Энэ жил 600 квот олгосон.

Түүнээс гадна, Монгол Улсын иргэд Оросын их, дээд сургуульд төлбөртэй суралцах боломжтой. Боловсролын хөтөлбөрийн үнэ нь Европ, Америк, Азийн орнуудын их дээд сургуулиудаас хамаагүй бага байдаг.

### ОРОС ХЭЛ СУДЛАЛ

- Монгол хүүхдүүдийг орос хөтөлбөрийн дагуу сургадаг Улаанбаатар хот дахь орос сургуулиуд
- Г. В. Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн Улаанбаатар хот дахь салбар
- Россотрудничество-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулдаг асуулт хариултын тэмцээний ялагчдад зориулсан Оросын хотуудын аялал



Россотрудничество-ийн «Здравствуй, Россия!» хөтөлбөрийн дагуу Олон улсын хүүхдийн «Артек» төв рүү явсан гурван монгол охин бүх Оросын «Их завсарлагаа» тэмцээнд амжилттай оролцсон. Харин тэмцээний ялагч Хэнзээ Номундарь Санкт-Петербург-Владивосток чиглэлийн аялалд явах болсон.



## МОНГОЛ ДАХЬ РУССКИЙ ДОМ

Орос, Монгол хоорондоо эртний найрсаг харилцаатай байсаар ирсэн. Шинжлэх ухаан, боловсрол, соёл, спорт болон бусад салбарын харилцаа холбоо хөгжиж байна. Орос-Монголын найрамдлын өдрүүд ба соёлын наадмууд тогтмол зохион байгуулагддаг. Оросын олон их, дээд сургуулиуд Монголын боловсролын байгууллагуудтай хамтран ажилладаг.

Оросын боловсролын тухай илүү их мэдээлэл олгохын тулд Россотрудничество-ийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газар сургуулийн сурагчдад зориулсан арга хэмжээ зохион байгуулдаг:

- орос хэл, байгалийн шинжлэх ухааны олимпиадууд – ялагчид Оросын их дээд сургуульд суралцах квотын эрхтэй болох боломжтой
- орос хэлний курс – амжилттай төгссөн сурагчид Оросын их дээд сургуульд суралцах квотын шалгаруулалтад оролцох боломжтой
- орос хэлтэй, мөн монгол хэл рүү орчуулсан төрөл бүрийн арга хэмжээ
- Оросын нэр хүндтэй их дээд сургуулийн төлөөлөгчид боловсролын хөтөлбөр болон элсэлтийн нөхцөлийн тухай танилцуулдаг боловсролын үйлчилгээний үзэсгэлэн

## ОРОСЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬД ЭЛСЭХ ЖУРАМ

1. Гадаадын иргэн нь хүчинтэй ЕЭШ байгаа эсэхээс үл хамааран их дээд сургуулийн бие даан авдаг элсэлтийн шалгалтыг өгч болно. Элсэлтийн хороо илүү өндөр дүнг тооцох болно.
2. Гадаадын иргэн улсын нэгдсэн шалгалт (ЕЭШ) болон элсэлтийн шалгалтын дүнг нэгтгэх эрхтэй. Жишээлбэл, элсэгч орос хэлний ЕЭШ-д илүү өндөр оноо авсан бол элсэлтийн хороонд тухайн дүнгээ танилцуулна. Гэхдээ математикийн ЕЭШ-ын оноо нь элсэгчийн хувьд хангалтгүй байгаа бол тэр дүнгээ сайжруулахын тулд элсэлтийн шалгалт өгөх боломжтой. Ингэсний үр дүнд илүү өндөр оноог сонгоно.
3. Гадаадын иргэн боловсролын тухай олон улсын гэрээгээр элсэх элсэгчдийн ангилалд багтсан, эсвэл эх орон нэгтнүүдийн статустай бол төсвийн орон тооны сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй. Оросын Засгийн газрын квотоор элсэх элсэгчид тусгай шалгаруулалтаар их сургуульд элсэнэ.
4. Эх орон нэгтнүүдийн статустай өргөдөл гаргагчид нийгмийн шинж чанартай, элсэгчийн гаргасан амжилт ололттой холбоотой онцгой эрхийг ашиглах боломжгүй.
5. Зарим их, дээд сургуульд гэрээгээр (төлбөртэй) элсэх гадаадын элсэгчдийн элсэлтийн шалгалтын тоог нэг хүртэл бууруулсан байдаг. Гадаадын иргэд Оросын дотоодын элсэгчдээс тусдаа шалгаруулалтад хамрагдана. Гэхдээ элсэлтийн шалгалтын тоог их сургууль өөрөө тогтоодог гэдгийг анхаарна уу. Энэхүү мэдээллийг элсэлтийн хорооноос тодруулах хэрэгтэй.
6. Гадаадын бичиг баримтыг орос хэл рүү орчуулах журамд өөрчлөлт орж байна. Зарим их дээд сургуулиуд энэ ажиллагаа өөрсдөө хийж эхэлсэн.
7. Баримт бичгийг хүлээн зөвшөөрсөн тухай гэрчилгээг (шаардлагатай бол) элсүүлэх зөвшөөрөл ирүүлсэн өдрөөс хэтрэхгүй хугацаанд өгөх шаардлагатай. Тиймээс та энэ ажиллагааг хаана хийх, хураамжаа хэрхэн тушаах болон бусад асуултуудыг тодруулна уу.
8. Шаардлагатай тохиолдолд гадаадын бичиг баримтыг хуульчлах хэрэгтэй.

$\frac{2x}{10} = 1{,}6$



$6-2-2=2$



mipt.ru







**ОХУ-Д НЭВТРЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- «Госуслуги» сайтаар дамжуулан Орост нэвтрэх маягтийг бөглөнө
- Хүчинтэй сөрөг ПЦР-тест байх шаардлагатай бөгөөд ОХУ-д ирснээс хойш 72 цагийн дотор давтан ПЦР-тест хийлгэнэ. ОХУ-д хийлгэсэн тестийн үр дүнг хүлээн авах үед оюутан өөрийгөө тусгаарлах ёстой. Гэхдээ тухайн оюутан зайнаас суралцах боломжтой
- ПЦР-тестийн хариу эерэг гарсан тохиолдолд элсэгч эсвэл оюутан хоёр долоо хоногийн хорио цээрийн дэглэмд хамрагдана
- Өдрийн анги хэлбэрээр үргэлжлүүлэн суралцахын тулд гадаадын оюутнууд хоёр ПЦР-тестийн сөрөг хариуг их сургуульд өгөх ёстой

**Оросын их дээд сургуульд элсэх, дасан зохицох, Орос дахь амьдралын тухай илүү ихийг мэдэхийг хүсвэл HED сэтгүүлийн бусад дугааруудыг уншина уу.**



**Зарим томоохон их дээд сургуулиуд гадаад оюутнуудыг хувийн амжилтын шалгаруулалтын үндсэн дээр бакалавр/магистр/специалитетийн хөтөлбөрт элсүүлдэг. Өргөдөл гаргахаар төлөвлөж буй их сургууль тус бүрт тусдаа хавтас бэлдээрэй.**

Жишээлбэл, Санкт-Петербургийн Улсын Их Сургуульд сэдэл бүхий захидал, сургалтын бэлтгэлийн тухай баримт бичиг, хөтөлбөр хэрэгжүүлэх хэлний мэдлэгийн түвшин, түүнчлэн хувь хүний амжилтыг үнэлдэг.

Оросын улс түмний найрамдлын их сургууль нь өмнөх боловсролын үр дүнгийн дундаж оноог харгалзан үнэлдэг. Ирээдүйн мэргэжлийн хичээл, төрөлжсөн мэргэжлийн тэмцээн уралдааны оролцоо, олон нийтийн байгууллага, нэгдэл, оросын ба гадаадын байгууллагуудын тодорхойлох захидалд онцгой анхаарал хандуулдаг. Магистрын хөтөлбөрт өмнөх их сургуулийн дэлхийн чансаанд эзлэх байр суурийг харгалзан үздэг.

**Оросын их, дээд сургуулийг төгссөн монгол залуус сургуулиа төгсөөд эх орондоо өндөр мэргэшилтэй буцан ирж, яам, томоохон аж ахуйн нэгж, эдийн засгийн бодит салбарт удирдах албан тушаал хашиж ажилласаар байна.**

# Төслийн оролцогч их сургуулиудын HED газрын зураг




Төв Холбооны тойрог
Баруун хойд холбооны тойрог
Өмнөд Холбооны тойрог
Хойд Кавказын Холбооны тойрог
Уралын холбооны тойрог
Ижил Мөрний Холбооны тойрог
Сибирийн холбооны тойрог
Алс Дорнодын Холбооны тойрог
Номхон далайн улсын их сургууль, Хабаровск 66



# БЕЛГОРОД

**Белгород муж** бол Оросын эдийн засгийн хувьд хамгийн амжилттай хөгжиж буй бүс нутгуудын нэг юм. Белгород мужийн нийслэл Белгород хот нь маш олон ногоон байгууламжтай, цэвэр агаартай.

**2021 онд Белгород муж Оросын амьдралын хамгийн өндөр чанартай топ-5 бүс нутагт багтсан**

- Байгаль орчинд сайнаар нөлөөлдөг ой мод ихтэй
- Орон сууцны үнэ хямд
- Хот маш цэвэрхэн
- Өндөр түвшний эмнэлгийн үйлчилгээ
- Гэмт хэргийн түвшин бага
- Амттай, цэвэр ус

## ДУНДАЖ ЗАРДАЛ

**10 000 RUB сард** – орон сууцны түрээс, ашиглалтын зардал багтаагүй

**8 000 RUB сард** – хоол хүнсний зардал

**200-250 RUB** – нэг удаа таксигаар явахад

**120-150 RUB** – нэг аяга капучино авахад

## ТЭЭВЭР

- Москва хүртэл 700 км зайтай, галт тэргээр нэг шөнө эсвэл онгоцоор нэг цаг нисээд очих боломжтой
- Белгород хотын олон улсын нисэх онгоцны буудал нь хот дотор байрладаг – троллейбусаар ч яваад очиж болно
- Белгород хотоос Москва руу өдөрт арван удаа нисэх боломжтой. Тасалбарын дундаж үнэ – 4 000 RUB
- Санкт-Петербург, Казань болон бусад хот руу тогтмол нислэг үйлддэг

## ДУЛААНЫ ДУНДАЖ ХЭМ

-8,5 °C
1 сард

+19,9 °C
7 сард

**Уур амьсгал** зөөлөн, намрын улирал дулаан, бороотой. Цас ихэвчлэн 10-11 сард ордог. Зарим өвөл их хүйтэн байдаг – 2 сард дулааны хэм -30 °C-аас доош бууж болно.

## АЛДАРТ КАФЕ

Белгород хотод «Оранжевый остров» хэмээх өөрийн гэсэн түргэн хоолны сүлжээ байдаг. Хоёр төрлийн олон нийтийн хоолны цэгүүдтэй. Жүрж өнгөтэй лангуунд цай, кофе, гурилан бүтээгдэхүүн зардаг. Боломжийн үнэтэй. Цэцэрлэгт хүрээлэн ба талбайд «Оранжевый остров»-ыг мини кафе ажилладаг. Хоолны цэс дотор бургер, салат, шөл, паста байгаа. Чек – 300-500 RUB.



**Алдарт хөгжимчид үе үе ирдэг драмын театр ба филармони ажилладаг**

Petr Magera flickr.com



# БЕЛГОРОДЫН УЛСЫН ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ

**1876 онд үүсгэн байгуулагдсан**

| | | |
|---|---|---|
| **9** сургууль | **2** коллеж | **1** салбар сургууль |
| **2** шинжлэх ухаан судалгааны хүрээлэн | **21** зэрэг хамгаалуулах зөвлөл | **56** шинжлэх ухааны төв ба лаборатори |
| **54** чиглэлийн шинжлэх ухааны судалгаа | **26 850** оюутан | **4 000+** дэлхийн 98 улсын 4000+ гадаад оюутнууд |

Байгалийн ухаан, хүмүүнлэг, техник, сурган хүмүүжүүлэх ухаан ба анагаах ухааны чиглэлээр өндөр зэрэглэлийн мэргэжилтэн бэлтгэнэ. Сургалтын явцад оюутнууд шинжлэх ухааны үйл ажиллагаанд хамрагдахаас гадна бизнесийн төслүүдийг хэрэгжүүлэхэд оролцдог.

Тасралтгүй боловсрол нь их сургуулийн өмнөх бэлтгэлээс эхлээд, аспирантур болон докторантурд шинжлэх ухааны боловсон хүчнийг хөгжүүлэх замаар үргэлжилдэг.

- bsuedu.ru
- vk.com/beluniversity
- t.me/bsuedu
- t.me/interhelp
- rutube.ru/channel/23627142

**Жилийн сургалтын төлбөр**

**2 380 – 4 900 USD**

«БелГУ» ҮСИС-ийн тухай кино

Виртуал нээлттэй өдөр

Элсэлтийн тухай бүх мэдээлэл

RAEX: **38** Оросын тэргүүлэгч их сургуулиудын дунд

Нар: Дээд лигт **5** хичээл

QS World University Rankings: **19-47** Оросд; **1001-1200** дэлхийд

**Орос улс, Белгород муж, Белгород хот**

## ДАВУУ ТАЛУУД

- Бэлтгэл ба боловсролын хөтөлбөрүүдийн өргөн сонголт, мэргэжлийн өндөр түвшний багш хамт олон, сайн материал техникийн сан
- Физик, математик, хими, биологи, анагаах ухаан, газарзүй, геологи, минералоги, инженерийн чиглэлээр дэлхийн жишигт нийцсэн чанартай судалгаа
- Практикт чиглэсэн сургалт, бизнесийн төслүүдэд оролцох боломж
- Гадаад хэлний гүнзгийрүүлсэн судлал, гадаадад дадлага хийх боломж
- Шилдэг оюутнуудад олгодог ректорын нэрэмжит нэмэлт тэтгэлэг
- Спорт, бүтээлч байдал, амралт, эрүүл мэндээ дэмжихэд зориулсан гайхалтай сайхан нөхцөл

## СУРГУУЛИЙН БҮТЦЭД

- Инженер ба дижитал технологийн сургууль
- Эм зүй, хими, биологийн сургууль
- Хууль зүйн сургууль
- Анагаах ухааны сургууль
- Багшийн сургууль
- Соёл хоорондын харилцаа ба олон улсын харилцааны сургууль
- Дэлхийн тухай шинжлэх ухааны сургууль
- Эдийн засаг, удирдлагын сургууль
- Нийгмийн шинжлэх ухаан, олон нийтийн харилцааны сургууль
- Анагаах ухааны коллеж
- Инженерчлэлийн коллеж
- «БелГУ» Үндэсний судалгааны их сургуулийн Старооскольскийн салбар сургууль



*Светлана Хоркинагийн сургалт биеийн тамирын цогцолбор*



## ОРОС ХЭЛИЙГ ГАДААД ХЭЛ БОЛГОН СОНГОЖ СУРАХ

- «Хүмүүнлэг», «Эдийн засаг», «Инженер техник», «Байгалийн шинжлэх ухаан» ба «Анагаах ухаан биологи» зэрэг чиглэлээр орос хэл дээр явагдах гадаад оюутнуудад зориулсан их сургуулийн өмнөх сургалт
- Хамтарсан хөтөлбөрүүдийн дагуу гадаад оюутнуудын давхар сургалт
- Орос хэлийг гадаад хэл болгон сонгосон сургалт (онлайн сургалт багтсан)
- Мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүд: «Гадаад оюутнуудын үндэсний онцлогийг харгалзан тэдэнтэй ажиллах онцлог», «Орос хэлийг гадаад хэл болгон сонгосон сургалт», «Орчин үеийн орос хэл»
- Олон улсын зуны хэлний сургууль

**Үнэ 1 800 USD**

vk.com/public189710848

Өргөдөл илгээх

**30** хамтарсан боловсролын хөтөлбөрүүд

**28** хоёр дипломын хөтөлбөрүүд

## ХОЁР ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРҮҮД

- Хятадын Дэжоу их сургуулийн дэргэдэх Белгородын Хүнсний шинжлэх ухааны сургууль
- Узбекистаны Каршинский Улсын Их Сургуультай хамтарсан факультетн

## АНГЛИ ХЭЛТЭЙ ХӨТӨЛБӨРҮҮД

**бакалавр**

- Хими
- Биологи
- Биотехнологи

**специалитет**

- Анагаах ухаан
- Эм зүй

**магистр**

- Олон улсын харилцаа
- Экологи ба байгалийн ашиглалт
- Эдийн засаг
- Аялал жуулчлал
- Хими
- Биотехнологи
- Математик
- Физик
- Материал хөтлөлт, материалын технологи
- Хууль зүй

## СУРГАЛТЫН ЭРЭЛТТЭЙ ЧИГЛЭЛҮҮД

- Анагаах ухаан, шүдний эмчилгээ
- Эдийн засаг
- Эм зүй
- Олон улсын харилцаа
- Сурган хүмүүжүүлэх боловсрол
- Сэтгүүл зүй ба хэвлэл мэдээллийн харилцаа холбоо
- Хууль зүй
- IT-технологи ба робот техник
- Экологи, хэрэглээний геологи, уулын мэргэжил



*Том нано бүтэцтэй материалын шинжлэх ухаан судалгааны лабораторид*



*Гадаад оюутнууд*



hedclub.com

## ТӨСВИЙН ТЭТГЭЛГЭЭР ЭЛСЭХ БОЛОМЖУУД

- ОХУ-ын Засгийн газрын квотын хүрээнд
- ОХУ-ын олон улсын гэрээний дагуу
- Гадаадад байгаа эх орон нэгтнүүдээ дэмжих хөтөлбөрийн дагуу

## БИЧИГ БАРИМТ

- Орос хэл рүү баталгаатай орчуулга хийлгэсэн паспорт ба түүний хуулбар
- Орос хэл рүү нотариатаар баталгаажуулсан орчуулга хийлгэсэн боловсрол эзэмшсэн тухай бичиг баримтын эх хувь ба хуулбар
- Гадаадын боловсролыг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ
- 086-У маягтын эрүүл мэндийн лавлагаа (тодорхой мэргэжлээр элсэх элсэгчдэд)
- 3×4 см хэмжээтэй 2 зураг

**Шаардлагатай тохиолдолд боловсрол эзэмшсэн тухай бичиг баримтыг тогтоосон журмын дагуу баталгаажуулах хэрэгтэй.**

Их сургуульд элсэхдээ гадаадаас элсэж буй элсэгчид "БелГУ" ҮСИС-ийн «Боловсрол эзэмшсэн тухай бичиг баримтын үнэлгээний шинжээчийн төв» хэмээх бүс нутгийн боловсрол арга зүйн төвд боловсролын баримт бичгийг хүлээн зөвшөөрүүлэх ажиллагааг хийлгэж болно.

Ажиллагааны үнэ **3 800 RUB**

**Дмитрий Сергеевич Срыбный**
+7 4722 30-10-80



**Аветис Григорян, Узбекистан. Багшийн сургуулийн гадаад хэлний тэнхимийн «Англи хэл ба түүх» мэргэжлийн хоёрдугаар курсын оюутан**

Би найз нөхдийнхөө зөвлөснөөр БелГУ-д элсээд, англи хэл сайн мэддэг учраас энэ тэнхимийг сонгосон. Манай тэнхим ирээдүйн багш ба орчуулагчдыг бэлтгэдэг. Мэргэжлийн хичээлүүдийг эхний семестрээс судалж эхэлсэн. Манай багш нар мэргэжлийн өндөр түвшинтэй, найрсаг хүмүүс байдаг. Техникийн хангамжийн хувьд хэрэгтэй бүх зүйл бэлэн байгаа.

Би 1-р дотуур байранд амьдардаг. Амьдрах нөхцөл маш сайн. БелГУ-ийн дотуур байрууд Орос дотроо шилдгүүд дотор багтдаг.

Оюутны хотхонд төрөл бүрийн биеийн тамирын талбайнууд байрладаг. Жишээлбэл хөлбөмбөгийн талбай, сагсан бөмбөгийн талбай, волейболын талбай, спортын хэрэгсэл болон турник бүхий тоглоомын талбай байдаг. БелГУ-д олон төрлийн спортын тэмцээнүүд байнга зохион байгуулагддаг.

Ирээдүйн нэгдүгээр курсын оюутнуудад би ийм зөвлөгөө өгөх хүсэлтэй байна: өөрийн дуртай зүйлээ хөгжүүл. Хаана, ямар сайхан байдаг тухай бусдын яриаг бүү сонс, ялангуяа танд сонирхолгүй байгаа бол!

**ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

+7 4722 30-10-82
inter@bsu.edu.ru

**ЭЛСЭЛТИЙН ХОРОО**

+ 7 4722 30-18-80
exam@bsu.edu.ru


ERWIN
РЕКА




pixabay.com




# МОСКВАГИЙН УЛСЫН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ «СТАНКИН»

**1930 онд үүсгэн байгуулагдсан**

| | | |
|---|---|---|
| **45** бакалаврын хөтөлбөр | **1** специалитетын хөтөлбөр | **53** магистрын хөтөлбөр, түүнчлэн англи хэл дээр |
| **17** аспирантурын хөтөлбөр | **5 000+** оюутан ба аспирант | **900+** дэлхийн 73 улсын 900+ гадаад оюутан |

Дижитал машин үйлдвэрлэлийн чиглэлээр тэргүүлэгч технологийн их сургууль, судалгааны хүчирхэг төв. Тус их сургууль нь сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа хувьд хүнд чиглэсэн боловсролын чиглэл болон төслийн хандлага ашиглан онцгой мэргэжилтнүүдийг бэлтгэдэг.

Төгсөгчид нь эдийн засгийн өндөр технологийн салбарууд, томоохон үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд, мэдээллийн технологийн салбар, «Аж үйлдвэр 4.0» технологийг нэвтрүүлэхтэй холбоотой орчин үеийн дижитал төслүүдэд эрэлт ихтэй байдаг.

- stankin.ru
- vk.com/msut_stankin
- t.me/msutstankin
- rutube.ru/channel/23638548
- tiktok.com/@stankin_main

Нээлттэй хаалганы өдөрлөг

**Сургалтын жилийн төлбөр**

**Бакалавр 220 000 – 250 000 RUB**
**Магистр 240 000 – 280 000 RUB**
**Аспирантур 280 000 – 300 000 RUB**

| Forbes | RAEX | RAEX | QS University Rankings: Emerging Europe & Central Asia | QS University Rankings: BRICS | Интерфакс |
|---|---|---|---|---|---|
| Оросод **29** | Оросод **54** | Оросод **29** Инженер-техникийн салбар | **241-250** дэлхийд | **291-300** дэлхийд | Оросод **81** **23-24** Судалгаа |

**Орос, Москва**

## ЭЛСЭЛТИЙН ОЛОН УЛСЫН ОЛИМПИАДУУД

**«МОСТ»**

Сургуулийн сурагчдын олон хичээлийн олимпиадууд

Бух оролцогчид сургалтын нийт хугацаанд 10% хөнгөлөлт эдэлнэ.

**Хичээлүүд:** Орос хэл, математик, физик, химиl, мэдээлэл зүй, нийгмийн ухаан.

**«Миний мэргэжлийн замнал»**

Магистрын ангид элсэж буй элсэгчдэд зориулсан олон хичээлийн олимпиадууд

Түрүүлсэн оюутнууд холбооны төсвийн зардлаар магистрын боловсрол эзэмших эрхтэй болно.

Бух оролцогчид сургалтын нийт хугацаанд 10% хөнгөлөлт эдэлнэ.

mycareer.stankin.ru

## ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орос хэл дээр явагддаг сургалтын хөтөлбөрүүдэд элсэхдээ гадаадын оюутнууд математик ба орос хэлний шалгалт өгнө

Англи хэл дээр явагддаг сургалтын хөтөлбөрүүдэд элсэхдээ англи хэл дээр ярилцлага өгнө



Элсэх өргөдөл гаргах

**Олон улсын хамтын ажиллагааны төвийн захирал**

**Надежда Юльевна Попова**

+7 499 972-94-11, +7 499 973-39-66

inter@stankin.ru

welcome@stankin.ru

n.popova@stankin.ru



*«СТАНКИН» МУТИС-ийн олимпиадууд*

## ЭЛСЭЛТИЙН БИЧИГ БАРИМТ

- Элсэгчийн иргэний үнэмлэх
- ОХУ-тай визтэй зорчих орнуудын хувьд эхлээд виз мэдүүлэх шаардлагатай
- Боловсролын түвшин ба (эсвэл) мэргэшлийн тухай гадаад улсын баримт бичгийн эх хувь (эсвэл зохих ёсоор баталгаажуулсан хуулбар), түүний хавсралт
- Боловсролын түвшин ба (эсвэл) мэргэшлийн тухай гадаад улсын баримт бичиг, түүний хавсралтын орос хэл рүү хийсэн орчуулга
- Их сургуульд суралцахад эсрэг заалт байхгүй болохыг баталгаажуулсан эрүүл мэндийн бичиг баримт, тогтоосон маягтын дагуу
- 6 зураг (матт энгийн, 3×4 см) болон 6 зураг (матт энгийн, 2×3 см)
- Сургалтын төлбөр, байр (1 жилийн хугацаатай), эрүүл мэндийн даатгалын зардлыг төлөхөд хангалттай хэмжээний мөнгө

## БЭЛТГЭЛ АНГИ

Орос хэл зааж, их сургуульд элсэхэд бэлдэнэ.

**Төлбөр 65 000 – 220 000 RUB**

Бэлтгэл ангийг амжилттай дүүргэсний дараа их сургуульд цаашид суралцахад хувь хүний хөнгөлөлт үзүүлэх боломжтой.


Бэлтгэл ангийн сурагчид

| Сургалтын эрэлттэй чиглэлүүд | Бакалавр | Магистр | Аспирантур |
|---|---|---|---|
| Мэдээлэл зүй ба тооцооллын техник | ✔ | ✔ | ✔ |
| Програм хангамжийн инженерчлэл | ✔ | ✔ | |
| Багаж үйлдвэрлэл | ✔ | ✔ | |
| Машин үйлдвэрлэл | ✔ | | ✔ |
| Технологийн процесс болон үйлдвэрлэлийн автоматжуулалт | ✔ | ✔ | |
| Машин үйлдвэрлэлийн зохион бүтээлт-технологийн дэмжлэг | ✔ | ✔ | |
| Мехатроник ба робот техник | ✔ | ✔ | |
| Техносферийн аюулгүй байдал | ✔ | ✔ | |
| Материалын шинжлэх ухаан ба материалын технологи | ✔ | | |
| Чанарын менежмент | ✔ | | |
| Техникийн системийн менежмент | ✔ | | ✔ |
| Эдийн засаг | ✔ | | ✔ |
| Менежмент | ✔ | ✔ | |
| Физик ба одон орон судлал | | | ✔ |
| Философи, ёс зүй ба шашин судлал | | | ✔ |

## ТЭТГЭЛЭГ

Их сургуулийн шинжлэх ухаан, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, мэдлэгээ хөгжүүлэх онцгой чадварыг харуулсан оюутнуудад нэмэгдүүлсэн тэтгэлэг олгож, хувь хүний хөнгөлөлт үзүүлдэг.

## ДАДЛАГА ХИЙХ БА АЖИЛД ОРОХ

РОСКОСМОС
Ростех
РОСАТОМ
САЛЮТ
1С
ЭНЕРГИЯ
Bosch Rexroth
SolidWorks
SIEMENS
KUKA ROBOTICS
МегаФон
Концерн ПВО Алмаз-Антей
МГЦ УОТ
Промсвязьбанк


Робот техник ба мехатроникийн лаборатори


Соёлын нэгдэл



**Батдэлгэр Булгантамир, Монгол Улс. «Технологийн машин ба тоног төхөөрөмж» чиглэлийн бакалаврын 1-р курсын оюутан**

«СТАНКИН» их сургуульд олон төрлийн инженерийн мэргэжлээр суралцах боломжтой. Орос хэл огт мэдэхгүй байх нь асуудал биш, их сургуульд гадаад оюутнуудад зориулсан орос хэлний 1 жилийн эрчимжүүлсэн сургалт байдаг.

Манай их сургуульд жинхэнэ мэргэжлийн өндөр чадвартай хүмүүс ажилладаг. Багш нар орос хэл, Оросын олон талт соёл ба түүхийг судлахад тусалдаг.

Би дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүстэй танилцсан. «СТАНКИН» их сургуульд суралцах нь надад үнэхээр таалагддаг.





**Майбат Оюумаа, Монгол Улс. «Програм хангамжийн инженерчлэл» чиглэлийн бакалаврын 1-р курсын оюутан**

Энэ их сургууль нь инженерийн чиглэлдээ тэргүүлэгч их сургууль учраас би «СТАНКИН» МУТИС-ийг сонгосон.

Орос хэл заахаас эхлээд энд сургалтын чанар маш өндөр байдаг. Багш нар амьдралын зорилгоо олоход бидэнд тусалдаг.

Их сургууль болон миний хичээл зүтгэлийн ачаар надад олон шинэ боломж бий болсон.



**Нямдорж Хажидмаа, Монгол Улс. «Хүний нөөцийн менежмент» чиглэлийн магистрын 1-р курсын оюутан**

Москвагийн их сургуулиудын дунд тэргүүлэх байр суурийг эзэлдэг учраас би СТАНКИН-ийг сонгосон.

Энэ жил би орос хэл сурсан. Өндөр ур чадвартай багш нартаа маш их талархаж байна.

Энэ их сургуульд миний олон найзууд суралцдаг бөгөөд тэдэнтэй хамт бид мэдлэг чадвараа дээшлүүлсээр байна.




# А. Н. КОСЫГИНЫ НЭРЭМЖИТ ОРОСЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ (ТЕХНОЛОГИ. ЗАГВАР. УРЛАГ)

**1930 онд үүсгэн байгуулагдсан**

**90** бакалаврын хөтөлбөр

**10** специалитетын хөтөлбөр

**75** магистрын хөтөлбөр

**18** аспирантур болон туслах-дадлагын хөтөлбөр

**5** мэргэжлийн дунд боловсролын хөтөлбөр

**13** сургууль

**2** зэрэг хамгаалуулах зөвлөл

**10 400+** оюутан

**1 000+** дэлхийн 75 улсын 1 000+ гадаад оюутан

Виртуал нээлтэй хаалганы өдөрлөг

Сургалтын чиглэлүүд ба мэргэжлүүд

Оюутны хотхон

Өргөн боломж болон тасралтгүй боловсролын уян хатан тогтолцоо бүхий олон талт шинжлэх ухаан, боловсролын төв. «Технологи. Загвар. Урлаг» гэдэг нь ирээдүйн мэргэжлийг үүсгэх концепцийг агуулсан гурвал юм.

**Жилийн сургалтын төлбөр**

**Бакалавр 99 000 – 373 200 RUB**
**Специалитет 198 000 – 373 200 RUB**
**Магистр 150 000 – 450 000 RUB**
**Аспирант 300 000 – 315 000 RUB**
**Туслах-дадлага 440 400 RUB**

kosygin-rgu.ru
vk.com/rsukosygin
t.me/rsukosygin

| Интерфакс | RUR | Univer.EXPERT |
|---|---|---|
| 86 | 764 | 121 |

Орос, Москва

| 1 | 1 | 2 |
|---|---|---|
| гимнази | коллеж | Тверь ба Новосибирск хотууд дахь 2 салбар |

## ЭЛСЭЛТ

1. **Төлбөртэй сургалт**
2. **Төсвийн зардлаар суралцах боломж**
   - ЕЭШ, дотоод шалгалт, олимпиадын дүнгээр (Оросын иргэдтэй хамт шалгаруулалтад оролцоно)
   - Оросын Засгийн газрын квотын хүрээнд

Беларусь, Казахстан, Киргизстан, Тажикистан улсын иргэд төсвийн зардлаар суралцах боломжтой. Бусад улс орны иргэд эх орон нэгтнүүдийн статусын тухай баримт бичиг, эсвэл квотын үндсэн дээр төсвийн зардлаар суралцах боломжтой.

Оросын нутаг дэвсгэрээс гадна оршин сууж буй гадаадын иргэд элсэлтийн хорооны шийдвэрээр элсэлтийн шалгалтыг зайнаас өгч болно.

Бүх бичиг баримтыг (иргэний үнэмлэх, боловсролын баримт бичиг гэх мэт) тогтоосон журмын дагуу орос хэл рүү орчуулсан байх ёстой. Шаардлагатай бол баримт бичиг нь апостиль, консулын албан ёсны зөвшөөрөл эсвэл боловсролын түвшинг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээтэй байх ёстой.

### ЭЛСЭЛТИЙН ХОРОО

+7 495 951-31-48
+7 495 811-01-01, нэмэлт дугаар 1300
priem@rguk.ru
vk.com/prkommgudt

## СУРГАЛТЫН ЧИГЛЭЛҮҮД

- Уран бүтээлч мэргэжлүүд – «Загвар ба урлаг»
- Инженерийн болон аж үйлдвэрийн шинжлэх ухаан
- Нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухаан
- Эм зүй – 2021 оноос



### БЭЛТГЭЛ АНГИ

**Чиглэлүүд:** хүмүүнлэг, эдийн засаг, инженер техник, анагаах ухаан биологи, байгалийн шинжлэх ухаан

**Сургалтын хугацаа** 10 сар

**Сургалтын хэлбэр** өдрийн анги ба зайны сургалт

**Анги** 8-12 хүнтэй

Хичээлийн хөтөлбөр нь орос хэлний аль ч түвшний мэдлэгтэй гадаадын иргэнд тохиромжтой.

Оюутнууд орос хэл, түүний соёл ба уламжлалыг судлаж, ТРКИ-1 улсын гэрчилгээ олгох шалгалтанд бэлдэнэ.

Бэлтгэл анги төгссөний дараа оюутнууд Оросын их дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцана.

**Төлбөр 160 000 RUB**

## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

**гадаадын их дээд сургууль ба байгууллагуудтай 70 гаруй гэрээ хэлэлцээр байгуулсан**

- Багшийн ба оюутны солилцоо
- Шинжлэх ухаан судалгааны хамтын ажиллагаа
- Боловсролын хамтарсан хөтөлбөрүүд
- Олон улсын дадлага

**Монголын их дээд сургуулиудтай**

- Монгол Улсын Үндэсний Техникийн Их Сургууль
- Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

## БОЛОМЖУУД

Оюутнууд боловсрол, инноваци, судалгаа, урлагийн чиглэлээр ажиллаж, эрдэм шинжилгээний хурал, загварын үзүүлбэрт идэвхтэй оролцож, зохиогчийн бүтээгдэхүүн бүтээн боловсруулж, өөрсдийн уран зургийн үзэсгэлэнгээ нээдэг.

Тус их сургууль нь жил бүр уран бүтээлийн арга хэмжээ зохион байгуулдаг: Бүх Оросын загварын наадам «Точка RU», гутал ба дагалдах хэрэгслийн загвар зохион бүтээгчдийн олон улсын тэмцээн «Shoes-Style» болон бусад арга хэмжээ.

**Их сургуулийн багш нарын дунд дэлхийд алдартай загвар зохион бүтээгчид байдаг: Вячеслав Зайцев, Валентин Юдашкин, Елена Теплицкая, Александр Васильев.**



## ОЛОН УЛСЫН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

- Бүртгүүлэх, виз авахад үзүүлэх дэмжлэг
- Тус улсад суралцахаар ирэх урилга
- Олон улсын хамтын ажиллагаа, дадлага явуулж зохион байгуулах

**Сургуулийн захирал**
**Татьяна Евгеньевна Колядина**
+7 495 811-01-01, нэмэлт дугаар 1495
imo@rguk.ru, priem@rguk.ru
vk.com/imorguk
www.imo-rguk.com

## МЭРГЭЖЛИЙН КАРЬЕРЫН ТӨВ

- Нээлттэй ажлын байрны жагсаалт
- Хийх боломжтой дадлагын тухай мэдээлэл
- Мэргэжлийн чанар ба ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ
- Мэргэжлийн салбарт хувь хүний өсөлт хөгжилтөд туслах зөвлөмжүүд

**90%**
Төгсөгчдийн 90% ажилтай

vk.com/careerrsu

**Одгэрэл Ундрам, Монгол Улс**

Би А.Н.Косыгины нэрэмжит Оросын улсын их сургуулийн бакалаврын оюутан.

Щинжлэх ухааны ажлын хүсэл тэмүүлэл ба хариуцлагатай хандлага бий болгох боловсролын оновчтой орчны үр дүнд шинжлэх ухааны үйл ажиллагаанд амжилт гаргах боломжтой гэдэгт би итгэдэг. А.Н.Косыгины нэрэмжит Оросын улсын их сургууль намайг гадаадын иргэний хувьд оюутны нийгэмлэгтэй харилцах ба нэгдэхэд туслах бүх шаардлагатай сайн нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

ОУИС нь надад хамгийн оновчтой бөгөөд орчин үеийн боловсролын технологи бүхий шинжлэх ухааны соёлын өргөн боломжийг нээж өгсөн.

Эдгээр бүх нарийн зүйлс нь надад үнэнч байдал буюу итгэлийн мэдрэмжийг төрүүлсэн бөгөөд энэ нь шилдэг үр дүнд хүрэх үүрэг хариуцлагыг бий болгодог гэж би бодож байна.

**Ганхуяг Ганчимэг, Монгол Улс**

Би 23 настай. Би А.Н.Косыгины нэрэмжит ОУИС-д суралцаж төгссөн. Харамсалтай нь тухайн үед коронавирусын цар тахал байсан, гэхдээ их сургуулийн тухай миний сэтгэгдэл сайхан хэвээр үлдсэн.

Багш нарынхаа ачаар би их зүйл сурсан. Хичээлээс гадна хэрхэн илүү сайн, илүү аз жаргалтай болохыг сурсан. Би олон дутагдалтай байсан ч гэсэн өдрөөс өдөрт хичээсээр ирсэн.

Гэрээсээ хол суралцаж байхдаа би шинэ сэтгэгдлүүдийн мэдэрсэн. Миний гэр бүл хамт байхгүй ч гэсэн шинэ найз нөхдийн тусламжид найдаж болно. Энд суралцах сайхан байсан!






# И. М. ГУБКИНЫ НЭРЭМЖИТ ОРОСЫН ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ (ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ)

1930 онд үүсгэн байгуулагдсан

**10** тэнхим

**23** бакалаврын чиглэл

**28** магистрын чиглэл

**3** магистрын олон улсын оролцоотой хөтөлбөр

**7** специалитетын чиглэл

**14** аспирантын чиглэл

**11 000** оюутан

**2 200** гадаад оюутан

**2** салбар сургууль

- Оренбург, Орос
- Ташкент, Узбекистан

Энэхүү их сургууль нь газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн бүхий л чиглэлээр сургалт явуулдаг: эрэл хайгуул, олборлолт, тээвэрлэлт, газрын тос ба байгалийн хийн боловсруулалт, технологийн процессын техникийн болон мэдээллийн дэмжлэгээс эхлэн газрын тос ба байгалийн хийн зах зээлийг эдийн засгийн болон олон улсын талаас нь судлах хүртэл.

**Жилийн сургалтын төлбөр**

**300 000 – 400 000 RUB**

www.gubkin.ru
vk.com/gubkin.university
t.me/gubkin_university

Их сургуулийн тухай кино

Тэнхимүүдийн нээлттэй өдөрлөгүүд

RAEX: **14** Инженер техникийн салбар

RAEX: **10** Ажил олгогчдын эрэлтээр

RUR: **23** Оросод; **553** дэлхийд

Орос, Москва

## ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Оросын Засгийн газрын квотоорчэлсэж буй элсэгчид орос хэлний шалгалт өгнө
- Төлбөртэй элсэж буй элсэгчид математик, орос хэлний шалгалт өгнө

Элсэлтийн дүрэмд өөрчлөлт орох боломжтой. **gubkin.ru** сайтаас мэдээлэл хараарай.

Гадаад иргэдийн элсэлт

***Жил бүрийн 11 болон 3 сарын сүүлийн ням гарагт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулдаг.***

Их сургуулийн сайт дээр онлайнаар холбогдох боломжтой **www.gubkin.ru**

## ЭЛСЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

**Суралцах хэл** – орос

Магистрын хөтөлбөрийн сургалт англи хэлээр явагдаж болно

**Орос хэл сурах боломж**

- их сургуулийн бэлтгэл ангид суралцана
- оршин суух улс орны ТРКИ сорил авах цэгүүдэд орос хэлний мэдлэгийн гэрчилгээ авна



## ГАДААД ОЮУТНУУДТАЙ АЖИЛЛАХ ХЭЛТЭС

**Хэлтсийн дарга**
**Александр Анатольевич Щербина**

+7 499 507-91-85

shcherbina.a@gubkin.ru

## ЭЛСЭЛТИЙН ХОРОО

+7 499 507-80-42

+7 499 507-84-06

priem@gubkin.ru

hotline@gubkin.ru

## ТЭНХИМҮҮД

- Газрын тос, байгалийн хийн геологи ба геофизик
- Газрын тос, байгалийн хийн орд олборлолт
- Дамжуулах хоолойн тээврийн системийн төлөвлөлт, барилга бүтээн байгуулалт, ашиглалт
- Инженерийн механик
- Автоматжуулалт ба тооцоолох техник
- Түлш эрчим хүчний салбарын цогц аюулгүй байдал
- Химийн технологи ба экологи
- Эдийн засаг ба менежмент
- Олон улсын эрчим хүчний бизнес
- Хууль зүйн тэнхим



## БЭЛТГЭЛ АНГИ

- **Бакалаврт элсэхэд**
  орос хэл, математик, физик, хими, шугам зураг, мэдээлэл зүй судална
- **Магистр болон аспирантурд элсэхэд**
  орос хэл, дээд математик, мэдээлэл зүй судална

Бэлтгэл ангийн төгсөгч төгсөлтийн шалгалтаа амжилттай өгсний дараа бакалавр / специалитет/ магистр / аспирантурын 1-р курсын элсэлтийн шалгалт өгөх эрхтэй болно.

**Сургалтын хугацаа** 1 жил

**Төлбөр** **220 000 RUB**

**Гадаад оюутнуудтай ажиллах хэлтэс**

dis@gubkin.ru

## ЭРЭЛТТЭЙ ЧИГЛЭЛҮҮД

- Газрын тос, байгалийн хийн мэргэжил
- Химийн технологи
- Эдийн засаг
- Менежмент
- Мэдээлэл зүй ба тооцооллын техник
- Мэдээллийн аюулгүй байдал



*Гадаад оюутнууд дадлага дээр*



*Их сургуулийн газрын тос, байгалийн хийн объектуудаар явах аялал*



*Бие даасан бэлтгэл*

## ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН МЭРГЭЖИЛ

### бакалавр

- Газрын тос, байгалийн хийн цооног өрөмдлөг (өдрийн анги)
- Газрын тосны үйлдвэрлэлийн байгууламжийн ашиглалт ба засвар үйлчилгээ (өдрийн анги)
- Хий, хийн конденсат олборлолтын объектууд болон газар доорх агуулахын ашиглалт, засвар үйлчилгээ (өдрийн анги)
- Хий, газрын тос дамжуулах хоолой болон хий, газрын тосны агуулах барилга бүтээн байгуулалт, засвар (өдрийн анги, өдрийн-эчнээ анги)
- Газрын тос, хий, боловсруулсан бүтээгдэхүүнийг тээвэрлэх ба хадгалах байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ (өдрийн анги, өдрийн-эчнээ анги)

- ☑ Тэнхимийн лабораторийн туршилтын ажлууд
- ☑ Хуурай газар болон далайн тэнгисд цооног өрөмдөх үйл ажиллагааг дууриайлган харуулах симулятор дээр ажиллах

### Мэргэжлийн ирээдүй

- Өрөмдлөгийн дарга, инженер-технологич
- Менежер
- Өрөмдлөгчийн туслах, өрөмдлөгч, цооногийн газар доорх засвар, газрын тос, байгалийн хийн олборлолт, өргөлтийн болон шахалтын шахуургын станц, ус, газрын тосны урьдчилсан бэлтгэлийн төхөөрөмжийн оператор
- Газрын тос, байгалийн хийн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн бага дарга
- Зураг төсөл, инженерчлэл, судалгааны аж ахуйн нэгжийн албан тушаал

**Гадаадын оюутнууд ихэнх нь дэлхийн олон улс орнуудын газрын тос, байгалийн хийн компаниудад эрэлттэй байдаг.**

## ХҮРЭЛЦЭН ИРЭХ

Нийслэл хотын зочдыг хот руу хүргэх үйлчилгээ

**Аэроэкспресс** – 300-с 400 хүртэл RUB

**Такси** – дунджаар 900 RUB

Хотын хамгийн тухтай бөгөөд хамгийн хурдан тээврийн хэрэгсэл бол метро юм. Метрогоор нэг удаа аялах зардал 60 рубль байдаг.

Их сургуульд очих амархан байдаг тул ирсэн хүмүүсийг **Ленинский проспект, 65-р байр, 1 корпус** хаягийн дагуу байрлах их сургуулийн нутаг дэвсгэр дээр тосож авна. Метроны буудал «Академичская».

Гадаадын иргэн хүрэлцэн ирэхэд визний бүрэн дэмжлэг үзүүлдэг. Эрүүл мэндийн даатгалыг гадаадын иргэн өөрөө худалдаж авна.

Сургалтад хамрагдахаар ирсэн гадаадын бүх иргэдийг их сургуулийн оюутны байр буюу нэг өрөөнд 2-3 хүний багтаамжтай тохилог дотуур байранд байрлуулдаг. Жилийн төлбөр нь ойролцоогоор 20 000 RUB болно.

---

**Олон үндэстний соёлын долоо хоног** бол их сургуульд суралцдаг олон үндэстний хоорондын харилцааг сайжруулахад чиглэсэн жил бүр зохион байгуулдаг арга хэмжээ юм. Хөтөлбөрт дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн ард түмний өвөрмөц үзмэрүүдийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн, квест-тоглоом, «Кино таах» тэмцээн, үндэсний хувцасны үзүүлбэр, дэлхийн ард түмний хоол болон гала-тоглолт зэрэг багтдаг.

## ОЮУТНЫ ХОТХОН

- Дотуур байрны 5 корпус, 4 000 гаруй хүн амьдарна
- Биеийн тамирын заал, цанын бааз, дасгалын талбай бүхий хөлбөмбөгийн талбай, сагсан бөмбөг, волейболын талбай
- Бүжиг, хөгжмийн зэмсэг, театрын студи, шатрын клуб, кино-клуб, урлаг, дуу бичлэгийн студи



### ОЛОН ҮНДЭСТНИЙ НӨХӨРЛӨЛИЙН КЛУБ

Энэхүү олон нийтийн залуучуудын байгууллага нь оюутнуудыг Орос болон гадаад орнуудын олон ард түмний соёл, уран бүтээлтэй танилцуулдаг. Тус клуб нь их сургуулийн дэргэдэх 22 нутгийн холбоодтой хамтран ажилладаг. Хичээлийн жилийн эхэнд тэд элсэгчдийн жагсаалтаас «өөрийн улсын» залуусыг олж, нэгдүгээр курсын оюутнууд их сургууль болон Оросод амьдрахад дасан зохицоход нь тусалдаг.



«Баатруудын уралдаан»






# Н. И. ПИРОГОВЫН НЭРЭМЖИТ ОРОСЫН ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ АНАГААХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

**1906 онд үүсгэн байгуулагдсан**

**12**
бакалавр, специалитет, магистрын хөтөлбөр

**60**
ординатурын хөтөлбөр

**5**
аспирантурын чиглэл

**3**
давхар дипломын хөтөлбөр

**2 100**
ордианатор ба аспирантууд

**11**
зэрэг хамгаалуулах зөвлөл

**12 000**
их сургуулийн өмнөх бэлтгэлийн хөтөлбөрт хамрагдсан сурагчид

**8 300**
оюутан

**1 256**
дэлхийн 61 улс орны 1 256 гадаад оюутан

Н.И. Пироговын нэрэмжит ОҮСАУИС бол эмч, эм зүйч, клиникийн сэтгэл судлаач, нийгмийн ажилтан, түүнчлэн анагаах ухааны биохими, кибернетик, биофизикийн чиглэлээр шинжлэх ухааны онцгой боловсон хүчин бэлтгэдэг шинжлэх ухаан, боловсролын тэргүүлэх төв юм.

**Сургалтын жилийн төлбөр**

**Бакалавр ба специалитет**
**300 000 – 500 000 RUB**
**Ординатур 480 000 – 600 000 RUB**
**Аспирантур 375 000 – 405 000 RUB**
**Магистр 250 000 – 340 000 RUB**

rsmu.ru
vk.com/rnimu
t.me/daily_2med
zen.yandex.ru/rsmu

Их сургуулийн тухай

| THE World University Rankings | THE Impact Rankings | QS World University Rankings by subject | RUR | RAEX | Интерфакс |
|---|---|---|---|---|---|
| **1201+** Нийтлэг эрэмбэ | **80** Эрүүл мэнд хамгааллын хөгжилд оруулсан хувь нэмэр | **451-500** Анагаах ухаан | **569** дэлхийд **21** Оросод | **2** Анагаах ухаан ба эрүүл мэнд хамгаалал | **35** |

Москва, Орос



## ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

| | |
|---|---|
| Төсвийн зардлаар суралцах элсэгчдийн бичиг баримт хүлээн авалт | **6 сарын 20 – 7 сарын 25** |
| Гэрээгээр (төлбөртэй) суралцах элсэгчдийн бичиг баримт хүлээн авалт | **6 сарын 20 – 8 сарын 25** (хичээлийн шинэ жил 9 сарын 1-нд эхэлнэ) |
| | **10 сарын 15** (англи хэлээр суралцах хичээлийн шинэ жил 11 сарын 1-нд эхэлнэ) |

- Нээлттэй хаалганы өдөрлөгүүдийг биечлэн болон онлайнаар зохион байгуулна
- Олон улсын боловсролын үзэсгэлэнгүүд

youtube.com

## ИХ СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

- Их сургуулийн сайт дээр байрлах нээлттэй даалгавруудын тусламжтайгаар шалгалтанд бие даан бэлдэж, туршилтын тестийг хязгааргүй олон удаа давтах боломжтой
- Тестийг орос хэл дээр бөглөнө. Зуучлах хэлээр суралцахаар төлөвлөж буй оюутнуудын хувьд англи хэл дээр шалгалт өгөх боломжтой
- Үндсэн хичээлүүд – хими, биологи, орос хэл
- Хичээл тутмын босго оноо 50-56 оноо байна

**Хэлбэрүүд**

- Биечлэн
- Цар тахлын таагүй нөхцөл байдлын үед зайнаас

## ЭЛСЭЛТИЙН ХОРОО

**Хариуцах нарийн бичгийн дарга, Олон улсын тэнхимийн декан Надежда Александровна Былова**

+7 495 434-31-74

prk@rsmu.ru



*Симуляцийн төвийн ажил*





*Мэргэжил дээшлүүлэх ангиуд*






## ГАДААДЫН ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БЭЛТГЭЛ АНГИ

Орос хэл, физик, хими ба биологи.

### Бүтэн сургалт

**Хугацаа** – 10 сар

8 сарын 17-с 9 сарын 28 хүртэл бичиг баримт хүлээн авна

**Төлбөр 320 000 RUB**

### Экспресс сургалт

**Хугацаа** – 4 сар

12 сарын 15-с 01 сарын 30 хүртэл бичиг баримт хүлээн авна

**Төлбөр 160 000 RUB**

Сургалтыг амжилттай дүүргэсний дараа орос, англи хэл дээр гэрчилгээ олгоно. Тухайн баримтыг Оросын анагаах ухааны ба эм зүйн их дээд сургуулиудын нэгдүгээр курст ороход хүлээн авна.

## ЭЛСЭЛТИЙН БИЧИГ БАРИМТ

- Паспортын эх хувь
- Паспортын орос хэл рүү нотариатаар баталгаажуулж хийлгэсэн орчуулга
- Боловсролын тухай баримт бичиг ба түүний хавсралтын эх хувь
- Эрүүл мэндийн бичиг баримт: гэрчилгээ, вакцинжуулалтын гэрчилгээ, шинжилгээ, түүний дотор ХДХВ, гепатит, флюорографийн зураг
- Боловсролын тухай баримт бичиг, түүний хавсралтыг орос хэл рүү нотариатаар баталгаажуулж хийлгэсэн орчуулга

### АНХААРНА УУ!

Боловсролын тухай баримт бичгийн эх хувийг шаардлагатай тохиолдолд элсэгч нь эх орондоо хуульчлах ёстой (консулын хууль ёсны зөвшөөрөл/апостиль).

Үүнээс гадна, боловсролын түвшин дүйцүүлсэн тухай гэрчилгээ өгөх шаардлагатай.

**Эдгээр шаардлагууд нь боловсролын баримт бичгийг олгосон улсаас хамаарна.**

**ОХУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яамны жагсаалтад байгаа Оросын олимпиадуудад түрүүлсэн нь элсэлтэд нэмэлт оноо өгдөг.**

## СУРГАЛТ

5.0 голч дүнтэй ахлах курсын оюутнууд (4 ба түүнээс дээш) их сургуулийн сургалтын төлбөрийг 100% хөнгөлдөг Гаазын шагналдд хамрагдах боломжтой.

## БАКАЛАВР БА СПЕЦИАЛИТЕТЫН ХӨТӨЛБӨРҮҮД

- Ерөнхий анагаах ухаан
- Хүүхдийн анагаах ухаан
- Шүдний анагаах ухаан
- Анагаах ухааны биохими
- Анагаах ухааны биофизик
- Эмчилгээний кибернетик
- Эм зүй
- Клиникийн сэтгэл судлал
- Нийгмийн ажил
- Биологи



*Хүүхдийн эмгэг судлалын клиникийн хүрээлэнгийн мэс заслын өрөөнд*



*Сургалтын лаборатори*



“

**Гэрэлчимэг Уранчимэг, Монгол Улс**

Миний ээж, дүү хоёр маань Оросод амьдардаг болохоор би энд сурахыг хүссэн. Миний ээж ноосон бүтээгдэхүүн борлуулдаг хувийн бизнестэй. Би ахыгаа халамжлахын тулд тэдэнтэй хамт байхаар шийдсэн.

Их сургуулийн санал болгосон нөхцөлүүд надад таалагдсан учраас би Анагаахын хоёрдугаар сургуульд орохоор шийдсэн. Төсвийн зардлаар суралцахын тулд би зөвхөн химийн шалгалт өгсөн.

Хэлний бэрхшээлээс би хэзээ ч айж байгаагүй. Би орос хэлэнд маш их дуртай, түүнийг гайхалтай үзэсгэлэнтэй хэл гэж боддог. Монголд байхдаа би сургуульд нэг жил орос хэл сураад, дараа нь Москва болон Ростов-на-Дону хотуудад бэлтгэл ангид хоёр жил сурсан.

Хичээлээс гадна өөр хүнд хэцүү зүйл надад байгаагүй. Манай их сургуульд суралцахийм хэцүү гэж би огт төсөөлөөгүй. Гэхдээ одоохондоо би суралцаж чадаж байгаа. Эхний жил л их хэцүү байсан. Хоёр дахь жил нь илүү хялбар байх шиг байна.

Орос бол маш үзэсгэлэнтэй орон. Хүүхэд байхдаа ээжтэйгээ энд олон удаа ирж байсан бөгөөд энд сурахаар ирсэндээ харамсахгүй байна.

Н. И. Пироговын нэрэмжит ОҮСАУИС-ийн өөр улс орны оюутнуудын ярилцлагатай уншиж танилцаарай





pixabay.com



# ЭЗЭН ХААН I-Р АЛЕКСАНДРЫН САНКТ-ПЕТЕРБУРГИЙН ЗАМ ХАРИЛЦААНЫ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

1809 онд үүсгэн байгуулагдсан

**25** бакалаврын хөтөлбөр

**23** специалитетын хөтөлбөр

**29** магистрын хөтөлбөр

**22** аспирантурын хөтөлбөр

**22** шинжлэх ухаан, судалгааны төв ба лаборатори

**30+** шинжлэх ухааны сургууль

**12 000+** оюутан

**2 000+** дэлхийн 30 улсын 2 000+ гадаад оюутан

Оросын анхны инженерийн тээврийн их сургууль. Олон тооны чухал чиглэлээр дэвшилтэт сургалт явуулдаг: хүнд ба өндөр хурдны хөдөлгөөний зохион байгуулалт, цахилгаан соронзон тээврийн бүтээн байгуулалт, дижитал технологийн хөгжил, эрчим хүчний хэмнэлт, техносферийн аюулгүй байдал ба экологи, логистик гэх мэт.

**Семестрийн сургалтын төлбөр**

**Бакалавр 1 825 EUR-оос**
**Магистр 1 825 EUR-оос**
**Аспирантур 2 175 EUR-оос**

**Төгсөгчдийн 98,5 гаруй хувь нь их сургууль төгсөөд шууд ажлын байртай болдог. Залуу мэргэжилтний сарын дундаж цалин 45 000 RUB байдаг**

**СПЗХУИС-ийн оюутнууд** ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Засгийн газар, Санкт-Петербургийн Засгийн газар, «РЖД» ХХН-ийн Ерөнхий захирал буюу ТУЗ-ийн дарга нарын тэтгэлэгт хамрагддаг.

**СПЗХУИС бол дэлхийн их дээд сургуулиудын нэгдсэн жагсаалтын эхний 10%-д багтсан цорын ганц тээврийн их сургууль юм**

| QS University Rankings: Emerging Europe & Central Asia | Forbes | RUR |
|---|---|---|
| **351-400** | **45** | **809** дэлхийд **82** Оросод |

Орос, Санкт-Петербург

## ОЮУТНЫ АМЬДРАЛ

- Их сургуулийн тэргүүлэх эрдэмтдийн удирдлага дор шинжлэх ухааны дугуйлан болон судалгааны лабораториуд ажилладаг
- Эрдэм шинжилгээ, спорт, соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагаанд амжилт гаргахад нэмэгдүүлсэн тэтгэлэг олгодог
- СПЗХУИС-ийн оюутны шинжлэх ухааны тэтгэлэгийн уралдаан
- 7 чиглэлийн сайн дурын үйл ажиллагаа
- 12 оюутны бүлэг, түүнээс 2 нь бүтэн жилийн турш ажилладаг

**30+**
спортын төрөл

**200+**
арга хэмжээ жил бүр

**10+**
студи

**100+**
уралдаан, олимпиад, тэмцээний ялагч

## ОЛОН УЛСЫН ХОЛБОО

## ТЭНХИМҮҮД

- Автоматжуулалт ба ухаалаг технологи
- Тээврийн барилга бүтээн байгуулалт
- Тээврийн удирдлага, логистик
- Аж үйлдвэрийн болон иргэний барилга бүтээн байгуулалт
- Тээврийн ба эрчим хүчний систем
- Эдийн засаг ба менежмент
- Тасралтгүй боловсролын тэнхим
- Их сургуулийн өмнөх сургалтын тэнхим



СПЗХУИС-ийн гимнастууд

## ГАДААД ОЮУТНУУДЫН ДУНД ЭРЭЛТ ИХТЭЙ СУРГАЛТЫН ТОП-5 ЧИГЛЭЛ

- Цахилгаан эрчим хүч, цахилгаан техник
- Эдийн засаг
- Менежмент
- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн
- Төмөр замын ашиглалт

Өндөр хурдны төмөр замын тээврийн **Евразийн холбооны их сургууль** нь Европ болон Азийн тэргүүлэх техникийн их сургуулиудтай хамтран хэрэгжүүлж буй олон улсын боловсролын нээлттэй төсөл юм.

**Төгсөгчид** – зам харилцааны сайд нар, төр, улс төрийн зүтгэлтнүүд, тээвэр, барилга, аж үйлдвэр, шинжлэх ухааны томоохон аж ахуйн нэгжүүдийн удирдагчид, нэрт эрдэмтэд, соёлын зүтгэлтнүүд.



СПЗХУИС-ийн (Ленинградын төмөр замын инженерүүдийн дээд сургууль) төгсөгч Халтар Лувсан 2020 оноос хойш Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын алба хашиж байна



**ERASMUS+ төслийн хүрээнд «Өндөр хурдтай төмөр замын тээвэр. Дэд бүтэц, эдийн засаг, экологи» («Барилга бүтээн байгуулалт» сургалтын чиглэл) олон улсын магистрын онцгой хөтөлбөрийг дараах сургуулиудтай хамтран хэрэгжүүлдэг**

Дрезденийн технологийн их сургууль, Герман

Мадридын Политехникийн их сургууль, Испани

## ДАВХАР ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨРҮҮД

### англи хэлтэй

**бакалавр**

- **«Барилга», «Олон улсын бизнес»** Хэрэглээний Шинжлэх Ухааны LAB Их Сургууль, Финлянд

### хятад хэлтэй

- **«Төмөр зам, гүүр, тээврийн хонгилын барилга бүтээн байгуулалт», «Төмөр замын ашиглалт», «Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн», «Галт тэрэгний хөдөлгөөнийг хангах систем», «Менежмент», «Худалдааны мэргэжил», «Техносферийн аюулгүй байдал», «Цахилгаан эрчим хүч ба цахилгаан техник»** Бээжингийн тээврийн их сургууль, Хятад болон бусад хөтөлбөрүүд

## ТҮНШҮҮД

## ЦЕНТР РУССКОГО ЯЗЫКА ПГУПС

- Гадаадын иргэдэд (элсэгчдэд) зориулсан орос хэл судлалын боловсролын нэмэлт хөтөлбөрүүд
- Богино хугацааны ганцаарчилсан сургалтууд
- Соёл судлал, уран зохиол, загвар хэв маяг, бизнесийн харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хэл чиглэлийн гадаад оюутнуудад зориулсан тусгай сургалтууд
- Орос хэлийг гадаад хэл болгон заах зуны ба өвлийн сургуулиуд

**Сургалтын сарын төлбөр**
**180 €-оос**

+7 812 232-61-67
rlc@pgups.ru
russianlanguage.center

*Орос хэлний тэнхимийн сурагчдын баг гадаад оюутнуудад зориулсан «Санкт-Петербургт байгаа мэт» квест тоглоомын ялагч болсон.*



## ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Гадаад оюутнуудад шилжилт хөдөлгөөн, визний дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг.

+7 812 457-80-39
inter@pgups.ru



**Роман Полещук, СПЗХУИС-ийн оюутан**

Би «Тээврийн менежмент ба логистик» тэнхимийн «Худалдааны мэргэжил» чиглэлээр сурдаг. СПЗХУИС-ээс Финляндын LAB University of Applied Sciences сургуультай хамтран хэрэгжүүлдэг давхар дипломын хөтөлбөртэй танилцаад, «Олон улсын бизнес» хөтөлбөрөөр Финляндад нэг жил суралцахаар явсан. Энэ хөтөлбөр нь надад гадаадад суралцах, боловсролын системтэй танилцах, нэмэлт мэдлэгтэй болох, англи хэлний дадлага хийх, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүстэй танилцах боломж олгосон. Буцаж ирээд би СПЗХУИС ба LAB гэсэн 2 дипломтой болно. Энэ ердөө 5 жилийн дотор.



*Дотуур байр*

## ДЭД БҮТЭЦ

- 15 сургалтын байр, 8 дотуур байр
- Геологи-геодезийн бааз
- Биеийн тамирын ордон. Усан бассейн, биеийн тамирын заал, багийн спорт, бөхийн заал бүхий спорт цогцолбор
- Эмнэлэг
- Соёл, амралт чөлөөт цагийн төв: театрын студи, дууны болон бүжгийн хамтлаг, дүрслэх урлагийн студи, КВН болон бусад
- Сайн дурын ажлын төв

## ЭЦЭГ ЭХИЙН ГҮҮР

Оюутнуудын хичээлийн ирц, сурлагын амжилт, боловсрол, шинжлэх ухаан, спорт болон бусад салбарын амжилтын тухай мэдээлэл авах зорилготой эцэг эхийн хувийн танхим.

## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

СПЗХУИС нь оюутны аюулгүй байдалд онцгой анхаарал тавьдаг. Их сургуулийн цогцолборын бүх барилгууд, тэр дундаа дотуур байрыг видео хяналтын системээр хангагдсан хамгаалалтын алба 24 цагийн турш хамгаалдаг.



*Гадаад оюутнууд Петропавловская цайзаар аялж байна*

## ГАДААД ОЮУТНУУДЫН НИЙГЭМЛЭГ

СПЗХУИС-ийн олон улсын үйл ажиллагааны тухай сүүлийн үеийн мэдээлэл: гадаадад суралцах, давхар дипломын хөтөлбөр, богино хугацааны дадлага, гадаадын профессоруудын лекц болон бусад олон зүйл зохион байгуулж байна.

vk.com/interpgups




190

# САНКТ-ПЕТЕРБУРГИЙН АРХИТЕКТУР БАРИЛГЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

1832 онд үүсгэн байгуулагдсан

**35**
бакалаврын хөтөлбөр

**12**
специалитетын хөтөлбөр

**43**
магистрын хөтөлбөр

**17**
аспирантурын хөтөлбөр

**9**
шинжлэх ухаан техникийн хүрээлэн ба төв

**13**
шинжлэх ухааны сургууль

**12 000+**
оюутан

**1 000**
дэлхийн 70 улсын 1 000 гадаад оюутан

**200+**
аспирант

Сургалт, шинжлэх ухааны томоохон төв, баялаг түүх ба уламжлал бүхий архитектур, барилгын чиглэлийн Оросын хамгийн эртний их сургууль. Улс орны барилга, архитектур, тээвэр ба инженер байгаль орчны системийн салбар дахь шинэлэг хөгжлийг хангадаг.

Түүхэндээ СПАБУИС нь 80 000 орчим мэргэжилтэн бэлтгэсэн, түүний дотор 4 000 гаруйг гадаад мэргэжилтэн бэлтгэсэн.

Хэрхэн барилгачин, инженер, архитектор болох вэ?

Оросын ирээдүйг бүтээж байна

**Жилийн сургалтын төлбөр**

**157 100 – 360 000 RUB**

spbgasu.ru
vk.com/spbgasu_vk
t.me/spbgasu_official
youtube.com/user/spsuace

| QS University Rankings: Emerging Europe & Central Asia | QS World University Rankings by subject | RUR | RUR | RUR | RAEX |
|---|---|---|---|---|---|
| **401** | **151-200** Архитектур ба хот бүтээн байгуулалт | **88** Оросод | **25** Байгалийн шинжлэх ухаан | **46** Техникийн шинжлэх ухаан | **49** Оросод |

Орос, Санкт-Петербург

## ОЛОН УЛСЫН ЗУНЫ СУРГУУЛЬ
### Өдрийн анги

2023 оны зуны хөтөлбөрийн тухай мэдээлэлтэй СПАБУИС-ийн сайтаас танилцах боломжтой. Мэдээллийг 2022 оны 11 сард нийтлэх болно.



## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 8 олон улсын холбоо
- Гадаад түншүүдийн өргөн сүлжээ
- Оюутан солилцооны хөтөлбөрүүд
- Олон улсын төслүүд
- Сурган танилцуулах дадлага
- Хос дипломын хөтөлбөрүүд

**ОЛОН УЛСЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

+7 812 316-73-14
+7 812 712-63-40
pvs@spbgasu.ru
spbgasu.edu@gmail.com
international.spbgasu@gmail.com



*Төгсөлтийн дипломын ажлын хамгаалалт, Архитектурын тэнхим*

## ТЭНХИМҮҮД

- Архитектурын тэнхим
- Барилгын инженерийн тэнхим
- Автомашины замын тэнхим
- Инженерийн экологи ба хотын аж ахуйн тэнхим
- Эдийн засаг, менежментийн тэнхим
- Барилга, тээврийн салбарын шүүхийн шалгалт, эрх зүйн тэнхим



## ГАДААД ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН БЭЛТГЭЛ АНГИ

**Хичээлүүд:** орос хэл, математик, физик, уран зураг.

**Сургалтын хугацаа** 9-10 сар. Төгсөлтийн шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд гэрчилгээ олгоно.

**Төлбөр**

**208 000 RUB** – архитектурын чиглэл
**166 400 RUB** – бусад чиглэлүүд

- Орос хэлний зуны ба өвлийн эрчимжүүлсэн ярианы сургалт
- Орос хэл судлалын ганцаарчилсан хөтөлбөр


*Архитектурын студи*

- Тохилог дотуур байр, хоолны газар, кафе, буфет
- Хэвлэлийн графикийн лаборатори, уран баримлын анги, уран зургийн танхим, архитектурын студи ба үзэсгэлэнгийн танхим
- Шинжлэх ухаан, техникийн номын сан
- Бие даан хичээллэх өрөөнүүд
- СПАБУИС-ийн түүхийн музей, Санкт-Петербургийн тоосгоны музей
- Хууль зүйн клиник
- Төслийн студи
- Жолооны сургууль

## ДОТУУР БАЙР

Өдрийн ангид элссэн болон бэлтгэл ангид суралцаж буй гадаадын бүх иргэнийг тохилог амьдрах орчин нөхцөл бүхий дотуур байраар хангадаг. Тус дотуур байр нь Санкт-Петербург хотын түүхэн төвд, их сургуулиас 10-15 минутын зайд байрладаг.

Хатуу нэвтрэх системтэй, видео хяналт ашигласан найдвартай хамгаалалт ажилладаг. Интернэт сүлжээгээр хангагдсан.

Төрөл бүрийн кафе, хоолны газар, дэлгүүр, «Сенной» захын ойрхон байдаг. Та «Юсуповын цэцэрлэгт хүрээлэн» хэмээх үзэсгэлэнт түүхэн цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалж, харин хотын секци болон клубуудад спортоор хичээллэх боломжтой.

**Жилийн төлбөр 18 000 – 72 000 RUB**

### Гадаадын иргэнд зориулсан мэдээлэл

- Эрүүл мэндийн даатгал байгуулах
- Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх
- Дотуур байранд нүүж орох

## БИЕИЙН ТАМИРЫН АМЬДРАЛ

### Биеийн тамирын хичээллэх чиглэлүүд

- Автомашины спорт
- Сагсан бөмбөг
- Бокс
- Бөх
- Гар бөмбөг
- Хөнгөн атлетик
- Хөл бөмбөг
- Хоккей
- Уран сайхны гимнастик
- Чирлидинг

### Биеийн тамирын эрүүлжүүлэх арга хэмжээ

- Эрүүл мэндийн өдрүүд
- Спартакиад
- Буухиа уралдаан
- Их сургуулиуд хоорондын хотын, бүс нутгийн, улсын ба олон улсын спортын тэмцээн уралдаан

**СПАБУИС оюутны спортын амжилтаар хотын шилдэг таван их сургуулийн тоонд багдаг.**


*Гар бөмбөг*


СПАБУИС-ийн дотуур байр, Фонтанка гудамжийн талаас


Үндсэн барилгын төв орц



Казанский сүм


СПАБУИС-ийн номын сан

**Санкт-Петербургийн түүхэн төв хэсэг** нь ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн Оросын анхны объект болсон юм. Хотын төв хэсэгт дөрвөн дүүрэг багтдаг: Адмиралтейский, Төв, Петроградский ба Василеостровский. Энэ хэсэгт Оросын хамгийн үзэсгэлэнтэй ордон, архитектурын чуулга, цэцэрлэгт хүрээлэн, түүнчлэн онцгой музей болох нийт 4000 гаруй архитектурын дурсгалууд байрладаг.

Хамгийн их хүн очдог газар бол Мойка, Фонтанка ба Нева голуудаар хязгаарлагдсан **Алтан гурвалжин** юм. Энэ бол 200 жилийн өмнө баригдсан харш ба ордон бүхий жинхэнэ нээлттэй музей юм.



Нева дахь Полтава хөлөг онгоц



ГУАП

# САНКТ-ПЕТЕРБУРГ ХОТЫН УЛСЫН АГААРЫН САНСРЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ИХ СУРГУУЛЬ

1941 онд үүсгэн байгуулагдсан

**10**
сургууль ба тэнхимтэй

**84**
чиглэлээр бакалавр, специалитет ба магистр бэлддэг

**12**
чиглэлээр аспирант бэлддэг

**9**
чиглэлээр мэргэжлийн дунд боловсрол олгодог

**15 000+**
оюутан

**1 000+**
дэлхийн 29 улс орноос ирж суралцдаг 1 000+ гадаад оюутан




ГУАП бол агаар-сансрын цогцолбор, удирдлагын систем, сүүлийн үеийн боловсролын технологийн чиглэлээр улс орны болон дэлхийн хэмжээнд тэргүүлэх түвшний шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудын нэг. Тус их сургууль нь олон төрлийн техникийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж, инженерийн боловсролын шинэ загварыг нэвтрүүлж байна.

ГУАП бол бүтээсэн ирээдүйн мэргэжлүүд болон хэрэгжүүлсэн **WorldSkills** ба **FutureSkills** ур чадваруудын тоогоор үндэсний тэргүүлэгч сургууль юм.

Их сургуулийн шинжлэх ухааны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд бол хиймэл оюун ухаан, «үүлэн» технологи, BigData, зүйлсийн интернет, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, робот техник юм.

- new.guap.ru
- vk.com/guap_ru
- t.me/new_guap
- tiktok.com/@guap.ru
- rutube.ru/channel/23832078

| QS University Rankings: Emerging Europe & Central Asia | Интерфакс | RAEX | SuperJob |
|---|---|---|---|
| **топ-350** | **топ-100** | **топ-20** шинэ эдийн засгийн их сургуулиудын дунд | **топ-15** Оросын техникийн их сургуулиудын дунд |

Орос, Санкт-Петербург

## ЭЛСЭЛТИЙН АЖИЛ

1. **priem.guap.ru** дээр элсэгчийн хувийн танхим үүсгэнэ
2. Өргөдөл, хувийн мэдээлэл боловсруулах зөвшөөрөл, элсэх зөвшөөрөл гаргана
3. Паспорт ба боловсролын тухай бичиг баримтаа орос хэл рүү орчуулж, нотариатаар батлуулж оруулна
4. Хувийн танхимдаа зайнаас элсэлтийн шалгалт өгнө

   **Бакалавр**

   **Техникийн чиглэлүүд:** Орос хэл ба математик, тест

   **Хүмүүнлэгийн чиглэлүүд:** Орос хэл ба математик/гадаад хэл сонголтоор, тест

   **Магистр**

   Чиглэлийн шалгалт – тест
5. Төлбөртэй боловсролын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулна

**Жилийн сургалтын төлбөр**
**240 000 – 294 000 RUB**

ГУАП-д элсэж суралцаарай

Элсэгчийн хувийн танхим

Элсэлтийн тухай мэдээлэл

**Нэгдүгээр агаарын сансрын сургуульд бичиг баримтаа өгөөрэй**

### ЭЛСЭЛТИЙН ХОРОО

+7 812 312-21-07
priem@guap.ru




## ОРЧИН ҮЕИЙН СУРГАЛТЫН СУУРЬ

- Инженерийн сургууль
- Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх төв
- Тэргүүлэгч аж ахуйн нэгжүүдийн суурь тэнхимүүд
- Орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон лабораториуд
- Шинжлэх ухаан, үзэсгэлэнгийн төв


*Сансрын системийн инженерчлэл*

### ГАДААД ОЮУТНУУДТАЙ АЖИЛЛАХ ХЭЛТЭС

+7 812 312-25-77
iiep@aanet.ru
guap.info/ru/oris

**Гадаад иргэдийн элсэлт хариуцсан ажилтан**
**Ксения Романовна Хусаинова**
+7 911 002-95-89 WhatsApp, Telegram

## СУРГАЛТЫН ИРЭЭДҮЙТЭЙ ЧИГЛЭЛҮҮД

- Мэдээллийн систем ба технологи
- Програм хангамжийн инженерчлэл
- Биотехникийн систем ба технологи
- Нисдэг төхөөрөмж болон хөдөлгүүрийн техникийн ашиглалт
- Техникийн системийн менежмент
- Тээврийн үйл ажиллагааны технологи
- Инноваци
- Менежмент
- Хууль зүй
- Хэл шинжлэл



*Робот техникийн лаборатори, Baxter робот*

## БЭЛТГЭЛ САЛБАР

- Орос хэлийг гадаад хэл болгож сурах практик хичээл
  - Сууръ анги
  - Ахисан түвшний анги
- Оюутнууд болон эцэг эхчүүдэд элсэлт ба сургалтын тухай зөвлөгөө өгнө
- Их сургуульд элсэх гадаадын элсэгчдээс авах орос хэлний шалгалт
- Шилжин суурьших горимын асуудлаар оюутнуудад зөвлөгөө өгнө

**Их сургуулийн өмнөх бэлтгэлийн салбарын дарга**

**Елена Владимировна Белич**

+7 812 312-25-77

belich@hf-guap.ru

guap.info/ru/odp

## МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ БА ХЯНАХ СУУРИЛСАН СИСТЕМҮҮД

### Англи хэлтэй магистрын хөтөлбөр

2 жил сурна

Солилцооны семестр

Зуны дадлага

Суурилсан компьютерийн системүүд гэдэг нь мэдээлэл ба компьютерийн технологийн олон нийтийн өндөр технологийн зах зээл бөгөөд шинжлэх ухааны дэвшилтэт судалгаа ба хөгжлийн хамгийн өрсөлдөөнтэй салбар юм.

Ухаалаг утаснаас автомашин хүртэл, нисэх онгоц ба сансрын хөлгөөс эмнэлгийн тоног төхөөрөмж хүртэл, ухаалаг гэрийн системээс ухаалаг тээврийн систем хүртэл гэх мэт хаа сайгүй суурилсан системүүд байдаг.

**Оюутнууд ихэвчлэн дараах судалгааны чиглэлүүдээс төслийн сэдэв сонгодог:**

- Агаарын хөлгийн тоног төхөөрөмжийн холбооны протоколууд
- Симуляци болон системийн шалгалт
- Суурилсан системийн дизайн
- Суурилсан системд зориулсан програм хангамж хөгжүүлэлт
- Агаарын хөлгийн тоног төхөөрөмжийн шинжлэл ба шинэчлэл
- Видео боловсруулалт
- Гетероген тооцоолол



**Матниязов Азизбек, Туркменистан**

Санкт-Петербургийн Агаарын сансрын багаж хэрэгслийн их сургуульд суралцах нь надад онцгой сайхан сэтгэгдэл үлдээсэн. Мэргэжлийн болон суурь шатны бүх хичээлийг дээд зэргийн түвшинд заасан. Багш нар нь зөвхөн өөрийн салбартаа өндөр мэргэшсэн мэргэжилтнүүд төдийгүй амьдралын туршлагаасаа хуваалцахад бэлэн сонирхолтой хүмүүс байдаг. Гадаад харилцааны хэлтсийн ажилтнууд бидэнд өөрсдийн үр хүүхэд шигээ хандаж, бидний бүх асуудлыг шийдэж, бидэнд маш их хайртай байсныг би санаж байна.

Их сургуульд их хэмжээний хичээлийн бус арга хэмжээ зохион байгуулагддаг байсан: спортын тэмцээн, оюуны тэмцээн, авъяасын шоу, ГУАП-ын мистер ба миссис, музей театрын аялал гэх мэт.

Би 5000 гаруй км зам туулж, ГУАП-д элсэж орсондоо хэзээ ч харамсаж байгаагүй. Чин сэтгэлийн талархал, халуун дулаан дурсамжууд миний сэтгэлд үлдсэн!



**Каба Ибрагим, Кот-д'Ивуар**

Санкт-Петербургийн Агаарын сансрын багаж хэрэгслийн их сургуульд суралцсан нь миний их сургуулийн амьдралын хамгийн сайхан үе байсан. Би агаарын хөлгийн цахилгаан системийн техникийн ашиглалт, нислэг, навигацийн системийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан.

ГУАП-д суралцаж дууссаны дараа би Европын шилдэг агаарын сургууль буюу Францын Иргэний нисэхийн үндэсний сургуульд элсэн орсон, одоо энд би иргэний нисэхийн авионикийн салбарын инженерийн диплом авахаар дадлага хийж байна.

ГУАП-д суралцсанаар би олон улсын нисэхийн салбарт ахихад шаардлагатай ур чадвар ба мэдлэгтэй болж авсан. Их сургуулийн багш нар, удирдлагууд оюутнуудтай сайн харилцаатай байдаг. Оюутнуудын амжилтын төлөө бүхий л зүйлийг хийдэг!

Аэронавтикийн салбарт мэргэжлээ сонгосон хүн бүхэнд би ГУАП-ыг, тэр дундаа энэ мэргэжлийг сонгохыг зөвлөж байна.



*КосмоСтарт. Шинжлэх ухаан, техникийн дэвшлийн үзэсгэлэн*




*КосмоСтарт чуулган*



# САНКТ ПЕТЕРБУРГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ, ДИЗАЙНЫ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

1930 онд үүсгэн байгуулагдсан

**225** боловсролын хөтөлбөр

**53** магистрын хөтөлбөр

**18 900** оюутан

**19** монгол оюутан

**1 500** дэлхийн 42 улсын 1 500 гадаад оюутан

СПҮТДУИС бол уран сайхны технологийн чиглэлийн Оросын тэргүүлэх их сургууль юм. Сургалтын үндсэн чиглэлүүд нь загвар, загварын салбар, хөнгөн, хэвлэлийн ба целлюлоз цаасны үйлдвэрлэлийн технологи, химийн технологи, дулааны ба цахилгаан эрчим хүч, загварын болон хэвлэл мэдээллийн салбарын мэдээллийн технологи, сэтгүүл зүй, зар сурталчилгаа ба олон нийтийн харилцаа, аялал жуулчлал, эдийн засаг ба менежмент юм.

2021 онд энэ их сургууль нь **«Тэргүүлэх зорилт 2030»** улсын хөтөлбөрийн хүрээнд **хөнгөн аж үйлдвэр** (ухаалаг нэхмэл эдлэл, ухаалаг хувцас, шинэ шинж чанар бүхий нийлмэл материал) болон **целлюлоз, цаасны аж үйлдвэр** (байгаль орчинд ээлтэй хаягдалгүй үйлдвэрлэл), түүнчлэн **дижитал аж үйлдвэрийн загвар** чиглэлээр сургалт явуулдаг Оросын шилдэг 100 их сургуулийн тоонд багтсан

**Жилийн сургалтын төлбөр**
**72 000 – 468 000 RUB**

Нар
**Нэгдүгээр лиг**

ЛУЧШИЕ ОБРАЗОВАТЕЛЬНЫЕ ПРОГРАММЫ ИННОВАЦИОННОЙ РОССИИ 2022
15 ялагч хөтөлбөр

RAEX
**2**
Хөнгөн аж үйлдвэрийн технологи

RAEX
**топ-20**
Химийн технологи

интерфакс
**топ-20**
Боловсролын чанар

Орос, Санкт-Петербург

## ОЮУТНЫ БАЙРНЫ ОНЦЛОГ

- Их сургуулийн бүх хичээлийн байрууд Санкт-Петербургийн түүхэн төв хэсэгт байрладаг
- Өдрийн ангийн оюутнуудыг, түүний дотор төсвийн бус сургалтын хэлбэрээр суралцдаг оюутнуудыг оюутны дотуур байраар баталгаатай хангана
- Оюутны хотхон – дэд бүтэц хөгжсөн хотын дүүрэгт байрладаг арван таван давхар 6 байр, нэг өрөөнд 2-3 хүн амьдардаг

## ЭЛСЭЛТ

Энэ их сургууль нь «Соёл ба урлаг» олимпиад зохион байгуулдаг. Энэхүү олимпиадад түрүүлсэн эсвэл шагнал байр эзэлсэн гадаадын иргэд Оросын Засгийн газрын квотын хүрээнд элсэх эрхтэй болдог.

Ажлын жишээ

**Төсвийн бус сургалтын хэлбэрээр** эсвэл Оросын Засгийн газрын **квотын хүрээнд** элсэхийн тулд уран бүтээлийн багцыг (зураг, уран зураг, найруулгын 4-5 бүтээл) бүрдүүлж танилцуулахад хангалттай.

Элсэлтийн тухай асуулт гарвал цахим шуудангаар холбогдож болно oria@sutd.ru

sutd.ru
vk.com/priemsutd
twitter.com/SutdNews
youtube.com/c/SPSUTD



## ГАДААДЫН УЛС ОРНУУДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ АЖИЛ

- Боловсролын үзэсгэлэн, Оросын Засгийн газрын квотын хүрээнд гадаадын иргэдийг сонгон шалгаруулах хорооны ажилд оролцох
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох уулзалт, төрөл бүрийн чиглэлийн мастер ангиуд
- Төлбөргүй уран сайхны хичээлийн сургалтууд
- Их сургуулийн үндсэн хичээлийн чиглэлийн боловсролын лекц



## ГАДААД ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН БЭЛТГЭЛ АНГИ

Орос хэлээр ярьдаггүй эсвэл орос хэлний хангалтгүй мэдлэгтэй элсэгчдийг бэлтгэнэ (өдрийн анги болон зайнаас). Оюутнуудыг дотуур байраар хангана.

+7 812 310-41-49
poig@sutd.ru

Бэлтгэл ангийн боловсролын хөтөлбөрүүд

## ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ

СПҮТДУИС-ийн бүртгэл ба визний хэлтэс нь гадаадын элсэгчид болон оюутнуудад Оросын нутаг дэвсгэрт хууль ёсны дагуу оршин суух бичиг баримт бүрдүүлэхэд нь зөвлөгөө өгч, тусална.

- Орос руу суралцахаар ирэх урилга гаргах
- Санкт-Петербург хотод ирээд олон удаагийн суралцах виз гаргах
- Эрүүл мэндийн даатгал хийлгэх талаар зөвлөгөө өгөх
- Гадаадын иргэнтэй ганцаарчилсан хүсэлтээр уулзаж, дагалдан явах

Бид Оросод хууль ёсны дагуу оршин суух бичиг баримттай холбоотой **бүх асуултанд хариулах болно**

inter@sutd.ru

+7 812 315-08-93



## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Их сургуулийн бүх байгууламж дараах тоноглолтой:

- нэвтрүүлэх хатуу хяналт
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой видео хяналт
- хамгаалалтын цэг, 24 цагийн жижүүр
- тогтмол шалгалт

Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд бүх байгууламжийг халдваргүйжүүлэлт болон агаарын дахин эргэлтийн төхөөрөмжөөр хангасан.




## ОЮУТНЫ БАЙР

Их сургууль өдрийн ангийн бүх оюутнуудын байрлах оюутны байраар хангадаг.

Оюутны хотхон нь хотын дэд бүтэц хөгжсөн дүүрэгт байрлах арван таван давхар 6 барилгаас бүрддэг. Нэг өрөөнд 2-3 хүн амьдардаг.

**Сарын төлбөр:**

**2 800 RUB** – төсвийн бус хэлбэрээр суралцаж буй оюутнууд

**900 RUB** – төсвийн зардлаар дээр суралцаж буй оюутнууд



## ДАСАН ЗОХИЦОЛТ

**«Дасан зохицогчид»** бол нэгдүгээр курсын оюутнуудад шинэ хамт олон, шинэ сургалтын үйл явцын нөхцөлд дасан зохицоход тусалдаг хөтөлбөр юм.

**Гадаад оюутнуудын төв** нь дугуй ширээний уулзалт, харилцан ярианы клуб ба аялал зохион байгуулж, их сургуулийн бусад оюутны холбоотой хамтран ажиллаж, оюутнуудад шилжилт хөдөлгөөний бүртгэл, визний үйлчилгээний тухай Оросын хууль тогтоомжийн шаардлагыг дагаж мөрдөх, хэл сурахад тусалдаг.

**Нийгэм-сэтгэл зүй, хувийн хөгжлийн алба** нь шаардлагатай тохиолдолд оюутнуудад сэтгэл зүйн туслалцаа үзүүлдэг.

**Оюутны бүлгүүд:** сурган хүмүүжүүлэх, археологийн, хөдөө аж ахуйн, байгаль орчин хамгааллын, сайн дурын ажилчдын, түүнчлэн хөтөч нарын бүлэг байдаг.

## ИРЭЭДҮЙН ТӨСЛҮҮД

2020 онд энэ их сургуульд «Буцлах цэг – ПромТехДизайн» хэмээх ирээдүйн төслүүд дээр хамтран ажиллах өндөр технологийн платформ нээгдсэн. Энэхүү төсөл нь бүтээлч эдийн засаг, дижитал загвар ба технологийн салбарыг хөгжүүлэх зорилготой юм. Энд оюутнууд санаа нэгтэй хүмүүсийн баг бүрдүүлж, мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсож, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглаж, өөрсдийн бодол санаагаа хэрэгжүүлэх боломжтой.

## ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ

СПҮТДУИС-ийн оюутнууд дэвшилтэт номын сангийн системд, түүний дотор төлбөртэй тусгай санд нэвтрэх боломжтой. Тэд түүнийг дэлхийн аль ч цэгээс, тэр дундаа их сургуулийн хотхоноос ашиглах боломжтой.

## СПОРТ

Энэ их сургууль нь хотын 70 гаруй оюутны аварга шалгаруулах тэмцээнд оролцдог. Needles хөгжөөн дэмжигч баг нь дэлхийн шилдэг 5 оюутны хөгжөөн дэмжигч багийн тоонд багтдаг, харин сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй баг нь Оросын шилдэг оюутны багуудын нэг юм.

## ЗУГАА ЦЭНГЭЛ

Энэ их сургууль нь гадаадын оюутнуудыг соёлын шинэ уламжлалд хурдан дасан зохицоход нь туслах зорилгоор олон тооны томоохон тод арга хэмжээ зохион байгуулдаг. Тэдний дунд:

- «Шилдэг уламжлалтай бүжгийн бал» соёлын төсөл
- «Ээж ээ! Би тайзан дээр байна» нэгдүгээр курсын оюутнуудын наадам
- «Мисс СПбГУПТД» гоо үзэсгэлэн, авьяас чадварын уралдаан
- Сонгодог хөгжмийн тоглолт





Сурталчилгааны эрхтэйгээр гаргаж өгсөн





Kramst wikimedia.com




# НОМХОН ДАЛАЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

**1958 онд үүсгэн байгуулагдсан**

**16**
сургууль ба тэнхимтэй

**200+**
бакалавр, специалитет, магистр ба аспирантурын хөтөлбөрүүд

**500+**
багш

**50+**
профессор

**10 000+**
оюутан

**700+**
гадаад оюутан

**250+**
Оросын Засгийн газрын квотын дагуу гадаадын иргэдэд зориулсан төсвийн зардлаар суралцах эрх

НДУИС – хүн бүрт зориулсан их сургууль

НДУИС-ийн тухай бичлэг

Оросын Алс Дорнодын хамгийн том их сургуулиудын нэг бөгөөд бүс нутагтаа олон улсын боловсролын манлайлагч их сургууль. Инженер, эдийн засаг, хүмүүнлэг, нийгэм судлалын чиглэлээр, архитектур, загвар, сурган хүмүүжүүлэх, боловсролын салбарын өргөн хүрээний мэргэжилтнүүд бэлтгэдэг.

## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

**62 гадаадын түнш их сургууль**

- Оюутан солилцооны хөтөлбөрүүд
- Хос дипломын хөтөлбөрүүд
- Олон улсын тэтгэлэг, грантууд
- Зуны ба өвлийн хэлний хөтөлбөр
- Гадаадад хийх дадлага


*НДУИС-ийн төгсөгчид*

Орос, Хабаровскийн хязгаар, Хабаровск

## ШИНЖЛЭХ УХААН

- 20+ шинжлэх ухааны сургууль
- 50 аспирантурын шинжлэх ухааны мэргэжил
- 19 шинжлэх ухаан, судалгааны лаборатори
- 11 сургалт, шинжлэх ухааны лаборатори

## ОЮУТНЫ АМЬДРАЛ

- 7 оюутны нэгдэл
- 17 уран бүтээлийн студи
- 9 оюутны ХМХ
- 20+ спортын сургалт

**НДУИС-ИЙН САЙН ДУРЫН АЖИЛЧДЫН ТӨВ**

## ДЭД БҮТЭЦ

- Хоёр оюутны хотхонд байрлах 9 дотуур байр
- «Политенцентр» худалдааны цогцолбор
- Хоолны газар, кафе, дэлгүүр, автомат машин, банкны АТМ, угаалгын газар, үсчин
- Спортын талбай, бэлтгэлийн танхим
- Мотокроссын зам
- 7 сургалтын байр, 1 лабораторийн байр
- НДУИС-ийн шинжлэх ухааны номын сан – 1,6 сая бүтээлийн нөөцтэй
- Бизнес-инкубатор
- Музей
- Оюутны эмнэлэг
- «Берёзка» урьдчилан сэргийлэх эмчилгээний сувилал
- Усан бассейн, усан эрүүлжүүлэх төв



*НДУИС-ийн дотуур байр*



*НДУИС-ийн «Загвар дизайн» чиглэлийн гадаад оюутнууд Москвад болсон шинжлэх ухаан, практикийн бага хуралд оролцов*

## ГАДААД ИРГЭДИЙН ИХ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БЭЛТГЭЛ

**Хичээлүүд:** орос хэл, шинжлэх ухааны ярианы хэв маяг, тусгай хичээлүүд

**Чиглэлүүд:** хүмүүнлэг, эдийн засаг, инженер-техник, анагаах ухаан биологи, байгалийн шинжлэх ухаан

Төсвийн зардлаар суралцахаар (квотоор) болон төлбөртэй суралцахаар элсэлт авна.

Өдрийн ангийн болон зайны сургалт.



*Их сургуулийн өмнөх бэлтгэлийн хөтөлбөрийн сурагчид*

## ОЛОН УЛСЫН ЗУНЫ БА ӨВЛИЙН СУРГУУЛЬ

**Хичээлүүд:** орос хэл, эдийн засаг, экологи, чимэглэл гар урлалын урлаг

- Танхимын хичээл, мастер анги, танхимаас гадна хичээл
- Соёлын ба аялалын хөтөлбөр

**Үргэлжлэх хугацаа** 1-4 долоо хоног

## «ДРУЖБА» ОЛОН ҮНДЭСТНИЙ КЛУБ

- Нийгэм соёлын дасан зохицолд тусална
- Сургалтын үйл ажиллагааг олон улсын чанартай болгоно
- Гадаадын олон улс орнуудаас ирсэн оюутнуудын хооронд найрсаг харилцаа бий болгож, бэхжүүлнэ
- Олон тооны ард түмний хэл, түүх, зан заншлын тухай мэдлэгийг өргөжүүлнэ
- Оюутнуудын бүтээлч, оюуны чадварыг хөгжүүлнэ
- Өөрийн төслийг боловсруулах, хэлэлцэх, хэрэгжүүлэх баг ба нэгдэл бүрдүүлнэ

### ГАДААД ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО

Их сургуультай харилцаа холбоотой байхад тусалдаг бөгөөд туршлага солилцох, төгсөгчдийн мэргэжлийн болон бүтээлч чадавхийг хэрэгжүүлэх талбар болж өгдөг.

afg.pnu.edu.ru
alumni@pnu.edu.ru

## ЭЛСЭЛТИЙН БИЧИГ БАРИМТ

- Гадаад улсын паспортын хуулбар (орос хэл рүү нотариатаар баталгаажуулсан орчуулгатай)
- Хамгийн сүүлд авсан боловсролын баримт бичгийн хуулбар (орос хэл рүү нотариатаар баталгаажуулсан орчуулгатай)

### ГАДААДЫН ИРГЭДИЙН ЭЛСЭЛТ

study@pnu.edu.ru
+7 4212 72-07-12
Орос, Хабаровск хот, Тихоокеанская гудамж, б. 136, офис 241 төв



*Дипломын ажлын хамгаалалт*



*Комацу сургалтын төв*




*«Дэлхийн хоолны соёлууд» тэмцээн*



**Ахмади Али Рейза, Афганистан. Эдийн засаг, менежментийн сургууль**

Би их сургууль сонгохдоо Оросын олон хотод очиж, Хабаровскийн НДУИС-ийг сонгосон. Энд би Афганистанаас ирсэн цорын ганц оюутан байсан бөгөөд энэ нь намайг бусад орны залуустай уулзахад түлхэц болсон юм.

Би орос хэлээр огт ярьдаггүй, яаж мэндлэхээ ч мэддэггүй байсан болохоор эхний жил орос хэл сурсан. Одоо би хотын төв рүү тайван очиж, асуудалгүй харилцах боломжтой болсон.

Одоо бид математик, эдийн засгийн онол, гүн ухааны чиглэлээр суралцаж байгаа, гэхдээ миний ирээдүйн мэргэжилд зайлшгүй шаардлагатай мэдээлэл зүйн хичээл яагаад ч юм огт байдаггүй. Тиймээс бие даан их уншиж, судалж байгаа.



**Ксавье Франсуа Хабиншути, Руанда**

Эх орондоо би политехникийн коллежид компьютер технологийн багшаар ажилладаг байсан. Намайг аспирантурын хөтөлбөрөөр суралцах санал тавьсан. Би элсэх өргөдлөө өгөөд Номхон далайн их сургууль намайг шалгаруулж сонгосон.

Эхлээд би бэлтгэл ангийн инженерийн бүлэгт сурсан. Би орос хэл, ярианы хэв маяг, математик, физик, Оросын газарзүйн хичээлүүд судалсан. Хамгийн хэцүү нь орос хэл сурах байсан.

Руандад бид Оросын талаар сайн мэддэггүй. Дэлхийн хамгийн хүчирхэг таван улсын тоонд багтдаг супер технологитой улс гэдгийг л мэднэ. Би Орос руу явахдаа санаа зовоогүй. Би Оросын тухай уншаад энд цагдаа сайн ажилладаг гэдгийг мэдэж байсан. Хэрэв та хууль ёсны дагуу ирвэл бүгд тантай уулзахдаа баяртай байх болно.

Оросын боловсролын систем манайхаас илүү удаан хугацааны түүхтэй болохоор илүү хөгжсөн. Энд багш нар өөрийгөө сайжруулах боломж ихтэй, бас номын сан, лаборатори байдаг. Энэ үнэхээр сайхан.




*Онц төгсөгч*



*Олон үндэстний BOOM*




# Оросын их дээд сургуулиудын квотын шалгаруулалт

Оросын Боловсрол, шинжлэх ухааны яам ба Россотрудничество хамтран жил бүр улсын төсвийн тэтгэлэгт хамрагдах гадаадын иргэн, иргэний харьяалалгүй хүн, гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүдийг квотын хүрээнд Оросын их дээд сургуульд элсүүлэх тухай зарладаг. Оросын их дээд сургуулиас урилга авах нэг арга бол гадаадад буюу гадаадын иргэний оршин сууж буй улсад элсэгчдийн хооронд явуулах шалгаруулалтад тэнцэх явдал юм. Энэ үе шатыг илүү дэлгэрэнгүй авч үзье.

## КВОТООР ЭЛСЭХ

**1**

Элсэгчдийн шалгаруулалтыг тэдгээрийн оршин сууж буй улс орнуудад тухайн улсын төрийн боловсролын байгууллагууд, Оросын элчин сайдын яам болон гадаадын төлөөлөгчийн газрын төлөөлөгчдийн оролцоотойгоор Россотрудничество зохион байгуулж явуулдаг.

1. **edu.rs.gov.ru** сайтад бүртгүүлнэ
2. Шаардлагатай бүх бичиг баримтыг хавсаргана. Бүртгүүлэх үед танд аливаа нэг бичиг баримт танд байхгүй байгаа бол дараа нь хүлээн авсан даруйдаа хавсаргаж болно
3. Холбооны тойрог бүрт хоёроос илүүгүй нэгээс зургаа хүртэл их сургуулийг элсэх хүсэлтийн дагуу заана – жагсаалтын эхнийх нь хамгийн их элсэх хүсэлтэй сургууль байна гэсэн үг
4. Бүртгүүлсний дараа нэр дэвшигчдийн материалыг таны оршин сууж буй улс дахь Оросын төлөөлөгчийн газарт шалгаж үзнэ. Баримт бичгийг шалгах хугацаа, түүнчлэн өөр өөр улсуудад ярилцлага хийх хугацаа өөр байж болно. Энэхүү мэдээллийг таны оршин сууж буй улс дахь Оросын төлөөлөгчийн газраас мэдэх боломжтой
5. Таны оршин сууж буй улсад зохион байгуулагдах сонгон шалгаруулалтад оролцох урилгыг хүлээнэ
6. Хоёр дахь шатны шалгаруулалтанд орохыг зөвшөөрсөн нэр дэвшигчдийн жагсаалтаас өөрийгөө хайж олно

Бусад улсы орны нутаг дэвсгэрт зохион байгуулагдах сонгон шалгаруулалтын нэгдүгээр үе шат нь сорилт, боловсрол ба мэргэшлийн тухай баримт бичгийн шалгаруулалт, уран бүтээлч байдлын сорилт, хувийн амжилтын уралдаан, ярилцлага (түүнчлэн зайны), олимпиад гэх мэт хэлбэртэй явагдаж болно.

Сонгон шалгаруулалтын үр дүнд үндэслэн гадаадаас элсэгчдийн нэрсийн жагсаалтыг улс тус бүрээр нь гаргаж, тэдгээрийн материалыг хавсаргана. Үүнд эрүүл мэндийн лавлагаа, хэвлэгдсэн бүтээлийн жагсаалт зэрэг олон тооны баримт бичгийн багц багтсан байдаг бөгөөд ирээдүйн оюутан ямар их сургуульд элсэх хүсэлтэй байгаагаа энд заасан байна. Олимпиадын үр дүнд үндэслэн сонгосон элсэгчдийн жагсаалтыг шалгалт тус бүрээр тус тусад нь гаргана.

## 2

Оросын Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн нэр дэвшигч тус бүрийг шалгасан үр дүнгийн тухай мэдээллийг Россотрудничество руу илгээдэг бөгөөд тэрээр дараа нь Оросын болон гадаадын элчин сайдын яам, гадаад дахь төлөөлөгчийн газруудад мэдэгддэг. Зөвшөөрсөн нэр дэвшигчдийн бичиг баримтыг их дээд сургуулиуд руу илгээдэг.

Их сургууль нь гадаадаас элсэгчдийн жагсаалтыг 7-р сарын 1 хүртэл тодорхойлох ёстой. Хэрэв ирээдүйн мэргэжил нь бүтээлч чадвар, бие бялдар эсвэл сэтгэл зүйн онцгой чадвар шаардсан байх ёстой гэж үзвэл гадаадын иргэдээс нэмэлт шалгалт авч болно – тухайн шалгалт нь 8-р сарын 5-аас өмнө явагдах ёстой. Их сургуулийн шийдвэрээр энэ шалгалтыг алсаас өгөх боломжтой, гэхдээ элсэгчийг жинхэнэ өөрөө шалгалт өгч байгааг үнэн зөв тодорхойлсон байх шаардлагатай.

Элсэгчдийн сонгосон их дээд сургууль тэднийг сонгоогүй тохиолдолд яах вэ? Энэ тохиолдолд тэдний бичиг баримтыг хамгийн бага тооны гадаад оюутан суралцдаг бөгөөд ижил сургалтын хөтөлбөртэй хоёр их сургуульд санал болгож илгээдэг.

## 3

Элсэгч нь их сургуульд суралцахаар элсүүлэх тухай Оросын болон гадаадын төлөөлөгчийн газраас мэдэгдэл хүлээн авсны дараа их сургуулийн Олон улсын харилцааны хэлтэс эсвэл олон улсын тэнхимтэй цахим шуудан эсвэл утсаар холбогдож, хүрэлцэн ирэх өдрийн тухай мэдэгдэх шаардлагатай.

Оросын их дээд сургуульд суралцахаар ирэхээсээ өмнө зарим улс орны оюутнууд гадаадын боловсролын баримт бичгийг хүлээн зөвшөөрөх ажиллагаагаа хийх шаардлагатай байдаг. Хуульчлах журмын тухай HED сэтгүүлийн 6 дугаараас уншаарай.

Орос хэл рүү орчуулаагүй, орчуулга нь нотариатаар баталгаажаагүй, шаардлагын дагуу бүрдүүлээгүй, түүнчлэн оршин сууж буй улсын иргэд бие даан ирүүлсэн гадаадын элсэгчдийн баримт бичгийг хүлээж авахгүй.

## 4

Их сургуульд хүрэлцэн ирсний дараа Оросын нутаг дэвсгэрт шаардлагатай бүх бичиг баримтыг бүрдүүлэхийн тулд Олон улсын харилцааны хэлтэс эсвэл олон улсын тэнхимтэй холбоо барих хэрэгтэй. Ингэхийн тулд Оросод нэвтрэхдээ хил дээр үзүүлсэн паспорт болон шилжилт хөдөлгөөний картаа авчрах хэрэгтэй. Эрүүл мэндийн даатгалыг тусад нь байгуулна.

Боловсролын баримт бичгийг нотариатаар баталгаажуулаз ба хуульчлах

Боловсролын баримт бичгийг хүлээн зөвшөөрөх

Ямар их дээд сургууль сонгосон хөтөлбөрийн дагуу сургалт явуулдгийг харах

# Сайн уу, элсэгч ээ!

Мэргэжил болон их сургууль сонгоход бид туслах болно

БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ



НАВИГАТОР ШКОЛЬНИКА



Оросод суралцах

# Тэтгэлэг ба грант

**Гадаадын иргэд Оросын их дээд сургуульд үнэ төлбөргүй суралцахаас гадна тэтгэлэг ба грантад хамрагдах боломжтой**

**350 000+**
гадаад оюутнууд Оросын их дээд сургуулиудад суралцдаг

**20**
Гадаад оюутнууд дэлхийн 20 улс орноос хүрэлцэн ирж суралцдаг

**900**
Оросын 900 их сургууль

- Эх орон нэгтнүүдийг дэмжих хөтөлбөр
- Оросын Засгийн газрын тэтгэлэг
- Владимир Потанины нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр
- Оросын их дээд сургуулиудын тэмцээн уралдаан, олимпиадууд

HED
Higher Education Discovery
hedclub.com